

СХ
БҮРТГЭВ
№ 01



ashid



Asset Management



АШИД АРВИЖИХ ХАМТЫН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

НЭГЖ ЭРХИЙН
ТАНИЛЦУУЛГА

СЭХ
2022.08.14
БҮРТГЭВ
№ 01



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ НАРЫН АНХААРАЛД

“Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын сан нь Монгол улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмуудын дагуу нэгж эрхээ олон нийтэд нээлттэй санал болгож байна.

Энэхүү Сангийн Нэгж эрхийн танилцуулгыг Сангийн нэгж эрхийн анхдагч арилжаанд гаргасан 10'000'000 ширхэг нэгж эрхийг олон нийтэд арилжихтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн ба холбогдох хууль, журмаар шаардагдах мэдээллүүдийг бүрэн агуулахыг зорьж, мэдээллийн үнэн бодит байдлыг хангаж ажилласан болно.

Энэхүү Нэгж эрхийн танилцуулга нь хөрөнгө оруулагч таны хараат бус шинжилгээ хийн, үнэлгээ, дүгнэлт гаргахыг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та “Ашид Ассет менежмент ҮЦК” ХХК болон түүний үүсгэн байгуулж буй “Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх болон бусад холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа, шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа нь тодорхой эрсдэлтэй байдаг гэдгийг анхаарна уу.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС “АШИД АРВИЖИХ” САН БАЙГУУЛАХЫГ ЗӨВШӨӨРЧ, НЭГЖ ЭРХИЙГ БҮРТГЭСЭН НЬ УГ САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ НЭГЖ ЭРХИЙГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА, НЭГЖ ЭРХ ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү Нэгж эрхийн танилцуулгад тусгагдсан аливаа мэдээллийн талаар илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл авах, лавлаж тодруулахыг хүсвэл Санг үүсгэн байгуулж буй хөрөнгө оруулалтын менежментийн компани болох “Ашид Ассет менежмент ҮЦК” ХХК-д болон өөрийн үнэт цаасны брокер, санхүү, хөрөнгө оруулалтын зөвлөхөд хандана уу.



АГУУЛГА
ХҮСНЭГТ
ЗУРАГ
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

1. “АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

- 2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД
- 2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ БОЛОН БҮТЭЦ
- 2.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
- 2.4 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН
- 2.5 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН
 - 2.5.1 Гадаад зах зээл
 - 2.5.2 Дотоод зах зээл
 - 2.5.3 Хөрөнгийн биржийн өнөөгийн нөхцөл байдал

3. “АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

- 3.2.1 Сангийн хөрөнгө оруулалтын зорилго, активын бүтэц
- 3.2.2 Модель багц ба багц боловсруулах аргачлал
- 3.2.3 Нээлттэй өмчлөлийн хэрэгсэлд хөрөнгө оруулах стратеги
- 3.2.4 Засгийн газар, нийслэл, компанийн өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах стратеги
- 3.2. Бэлэн мөнгө болон хадгаламжийн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах стратеги
- 3.2.6 Хөрөнгө оруулах хэрэгслүүдэд тавих хязгаарлалт
- 3.2.7 Хөрөнгө оруулалтын судалгаа, багцын шинжилгээ

3.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 3.3.1 Сангийн бүтцийн схем
- 3.3.2 Нэгж эрх эзэмшигчдийн хурал
- 3.3.3 Төлөөлөн удирдах зөвлөл
- 3.3.4 Гүйцэтгэх удирдлага
- 3.3.5 Дотоод хяналт, комплианс

3.4 САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ, ЖУРАМ, БОДЛОГО

3.5 САНГИЙН ХӨРӨНГӨ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

3.6 САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /BS, IS, CF/

- 3.7 САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭ
- 3.8 САНГИЙН ЗАРДАЛ
- 3.9 САНГИЙН ТАТВАР
- 3.10 САНГИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО
- 3.11 ТАТАН БУУГДАХ ТОХИОЛДОЛД ОРЛОГО ХУВААРИЛАХ БОДЛОГО
- 3.12 САН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ БОЛОХ АЛДАГДАЛ ХҮЛЭЭХ ТОХИОЛДОЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

4. “АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА


- 4.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
- 4.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
- 4.3 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

5. “АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА

- 5.1 ЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ
- 5.2 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛАН ХҮРГҮҮЛЭХ
- 5.3 НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА
- 5.4 НЭГЖ ЭРХИЙН НЭРЛЭСЭН ҮНЭ, ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ
- 5.5 ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
- 5.6 НЭГЖ ЭРХИЙН ӨГӨӨЖИЙН ТООЦООЛОЛ

6. “АШИД АССЕТ МЕНЕЖМЕНТ” ХОМК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

- 6.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
- 6.2 УДИРДЛАГА, КОМПАНИЙН БҮТЭЦ
- 6.3 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
- 6.4 ДОТООД ХЯНАЛТЫН АЛБА
- 6.5 МЕНЕЖМЕНТИЙН БАГ
- 6.6 БУСАД




ХҮСНЭГТ

- Хүснэгт 1. Хөрөнгө оруулалтын сангийн төрлүүд
- Хүснэгт 2. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл
- Хүснэгт 3. Хөрөнгө оруулалтын багцын харьцаа
- Хүснэгт 4. Модель багц, багцын өгөөж, хувийн жин
- Хүснэгт 5. МХБ-ийн нээлттэй хувьцаат компаниудын өгөөж /он, салбараар/
- Хүснэгт 6. Сангийн нэгж эрх гаргах болон буцаан худалдан авах төлөвлөгөө /сая төгрөг/
- Хүснэгт 7. Сангийн санхүү байдлын тайлангийн төсөөлөл /сая төгрөг/
- Хүснэгт 8. Орлого үр дүнгийн тайлангийн төсөөлөл /сая төгрөг/
- Хүснэгт 9. Мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл /сая төгрөг/
- Хүснэгт 10. Сангийн хөрөнгийн зохистой харьцаа
- Хүснэгт 11. Ногдол ашиг хуваарилалт
- Хүснэгт 12. ТУЗ-ийн гишүүдийн талаарх мэдээлэл
- Хүснэгт 13. Менежментийн багийн талаарх мэдээлэл

ЗУРАГ

- Зураг 1. Хөрөнгө оруулалтын сангийн хэлбэр, төрөл
- Зураг 2. Дэлхийн ДНБ-ий өсөлт /тэрбум, ам.дол/
- Зураг 3. Долларын ханш Рублийн эсрэг
- Зураг 4. Зэсийн үнэ /ам. доллар/
- Зураг 5. Төмрийн хүдийн үнэ /ам. доллар
- Зураг 6. 1 унц алтны үнэ /ам.доллар/
- Зураг 7. 1 баррел газрын тосны үнэ /ам.доллар/
- Зураг 8. Томоохон хувьцаат компаниудын ханшийн өөрчлөлт
- Зураг 9. S&P500 индекс
- Зураг 10. Эдийн засгийн өсөлтийн таамаглал
- Зураг 11. МХБ-ийн зах зээлийн үнэлгээ /тэрбум/
- Зураг 12. МХБ-ийн топ 20, MSE A, MSE B индексийн ханш
- Зураг 13. Efficient frontier and capital allocation line т
- Зураг 14. Сангийн үйл ажиллагааны схем
- Зураг 15. Сангийн цэвэр хөрөнгийн төлөвлөгөө
- Зураг 16. Сангийн нэгж эрхийн үнэлгээний төлөвлөгөө
- Зураг 17. Нөлөөллийн хөрөнгө оруулалт
- Зураг 18. "Ашид Ассет Менежмент ҮЦК" ХХК-ийн бүтэц



**Кастодиан**

Сангийн хөрөнгийг хадгалж, төлбөр, тооцоог гүйцэтгэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хөрөнгө оруулалтын сангийн гишүүдэд холбогдох мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээг үзүүлэх, кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээд.

Нэгж эрх

Нэгж эрх эзэмшигчээс Санд оруулсан хөрөнгийг өмчлөх эрхийг гэрчлэх нэрийн үнэт цаас.

Нэгж эрхийн танилцуулга

Хөрөнгө оруулалтын сангаас нэгж эрх эзэмшигчдэд хүргүүлсэн нэгж эрхийг худалдан авах саналтай холбоотой баримт бичгийн бүрдлийг

Нэгж эрх эзэмшигч

Хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулж, нэгж эрх эзэмшсэн иргэн, хуулийн этгээд.

Нэгж эрх эзэмшигчдийн хурал

Нэгж эрх эзэмшигчдээс бүрдсэн хөрөнгө оруулалтын сангийн эрх барих дээд байгууллага

Брокер

Харилцагчийн хөрөнгөөр, түүний нэрийн өмнөөс, түүний даалгавраар үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэхийг үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа гэнэ.

Дилер

Өөрийн нэрийн өмнөөс өөрийн хөрөнгөөр үнэт цаасыг худалдан авах ажиллагааг үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа гэнэ.

Ногдол ашиг

Компанийн жил бүрийн ашгийн хуваарилалт

Хөрөнгө оруулалтын сан

Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлагаар энэ хуулийн 4.1.18-д заасан үйл ажиллагааг эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл хаалттай хүрээнд төвлөрүүлсэн хөрөнгийн сан.

Хамтын хөрөнгө оруулалтын сан

Нэгж эрхээ нийтэд санал болгох замаар мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх эрх бүхий хөрөнгө оруулалтын сан.

Хөрөнгө оруулалтын хэрэгсэл

Үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, мөнгөний болон зохицуулалттай зах зээлд арилжихыг зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгсэл.

Үнэт цаас гаргагч

Үнэт цаасны зах зээлд арилжих үнэт цаасаа Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа этгээд.

Өрийн хэрэгсэл

Үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаа дуусмагц үндсэн төлбөр болон хүүг мөнгөн хэлбэрээр, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр тухайн үнэт цаасыг эзэмшигчид эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн болон түүнтэй адилтгах бусад үнэт цаас.

Хөрөнгө оруулалтын менежментийн компани

Хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний дагуу түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээд.

ҮЦК

Үнэт цаасны компани

Сан

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан

ХОМК

“Ашид ассет менежмент ҮЦК” ХХК

ТУЗ

Төлөөлөн удирдах зөвлөл

ДХХ

Дотоод хяналтын хороо

ІРО

Initial Public Offering гэх үгийн товчлол бөгөөд хувьцааг олон нийтэд санал болгож хөрөнгө оруулалт татах гэсэн утгатай.

Хороо



Санхүүгийн зохицуулах хороо

ДНБ

Дотоодын нийт бүтээгдэхүүн

МХБ

Монголын хөрөнгийн бирж



“АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ
ЭРХИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА





1. “АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Ашид Арвижих” Хамтын хөрөнгө оруулалтын сан нь 500'000'000 /таван зуун сая/ ширхэг зарласан нэгж эрхтэй байх бөгөөд нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 10'000'000 /арван сая/ ширхэг нэгж эрхийг анхдагч зах зээлийн арилжаанд гаргаж, үүний 95 /ерэн тав/ хувь буюу 9'500'000 /есөн сая таван зуун мянга/ ширхэг нэгж эрхийг олон нийтэд санал болгон арилжиж, 5 /тав/ хувь буюу 500'000 /таван зуун мянга/ ширхэг нэгж эрхийг санг байгуулагч ХОМК-с хөрөнгө оруулалт хийж нийт 1'000'000'000 /нэг тэрбум/ төгрөг татан төвлөрүүлж, тусгай зөвшөөрөл авснаар үйл ажиллагаагаа эхлүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдах компани	“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК
Сангийн нэр	“Ашид Арвижих” Хамтын хөрөнгө оруулалтын сан
Сангийн хэлбэр	Хамтын
Сангийн төрөл	Нээлттэй
Сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа	10 жил
Анхдагч арилжаагаар татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	1'000'000'000 /нэг тэрбум/ төгрөг
Анхдагч зах зээлийн арилжааны нэгж эрхийн нэрлэсэн үнэ	100 /нэг зуу/ төгрөг
Анхдагч зах зээлийн арилжаагаар гаргах нэгж эрхийн тоо	10'000'000 /арван сая/ ширхэг
Анхдагч арилжаагаар олон нийтэд санал болгож буй нэгж эрхийн тоо	9'500'000 /есөн сая таван зуун мянга/ ширхэг
Сангийн удирдлага	Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал
Хөрөнгө оруулалтын багц	Өсөлтийн багц Хувьцаа <=70%; Өрийн хэрэгсэл <=20%; Хадгаламж болон бэлэн мөнгө <=10%
Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний үндсэн хөлс	Удирдаж буй хөрөнгийн хэмжээнээс (AUM): 2.2%
Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний бонус урамшуулал	Цэвэр активын зорилтот өгөөжөөс давсан өсөлтийн: 20%
Зорилтот өгөөж /hurdle rate/	15%
Хөрөнгө хадгалах кастодиан	Голомт Банк ХХК
Хөрвөх чадвар	Сан нь хөрөнгө оруулагчийн нэгж эрхийг буцаан худалдан авах үүрэг хүлээж, төлбөр гүйцэтгэнэ.
Арилжааг зохион байгуулах байгууллага	“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК Сангийн онлайн платформ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН



2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

Хөрөнгө оруулалтын сан гэж хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг Хөрөнгө Оруулалтын Менежментийн Компанийн удирдлага дор мэргэжлийн төвшинд эрхлэх зорилгоор нийтээс, эсхүл хаалттай хүрээнд төвлөрүүлсэн хөрөнгийн санг хэлнэ. Хөрөнгө оруулалтын сан нь урьдчилан судалж төлөвлөсөн хөрөнгө оруулалтын бодлого стратеги, холбогдох хууль, журмын дагуу хөрөнгө оруулалтын оновчтой хувилбаруудыг сонгож эрсдэлийн удирдлага, хяналтын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг мэргэжлийн төвшинд удирдан хөрөнгө оруулагчдад үнэ цэн, өгөөж бий болгох үйл ажиллагаа явуулдаг. Хөрөнгө оруулагч болон сан буюу түүнийг үүсгэн байгуулагч Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хамтын зорилгоо хэрэгжүүлэхийн тулд харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны зарчмаа тодорхойлсон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулдаг.

Хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК) гэж хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний дагуу түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай хуулийн этгээд юм. Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооноос санхүүгийн чадавх, түршлага, мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн хууль журам, ёс зүйн хувьд "зохистой" байдал зэргийг харгалзан ХОМК-ийн тусгай зөвшөөрлийг олгодог.

Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалт болон өдөр тутмын үйл ажиллагааг Хөрөнгө оруулалтын менежментийн компани,

сангийн менежер явуулах хэдий ч сангийн эрх барих дээд байгууллага нь Хөрөнгө оруулагчдын буюу нэгж эрх эзэмшигчдийн хурал байна. Мөн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа нь хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхийг Монгол улсын Санхүүгийн зохицуулах хороо хянаж байдаг.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай Монгол улсын хуулийн дагуу Хөрөнгө оруулалтын сан нь Хамтын, Хувийн гэсэн 2 хэлбэртэй байдаг. Хамтын хөрөнгө оруулалтын санг мөн хаалттай болон нээлттэй гэсэн 2 төрөлд хуваадаг.

Санд хөрөнгө оруулагч болох иргэд, аж ахуйн нэгжүүд нь хөрөнгө оруулалтын сангийн бүтэц, хөрөнгө оруулалтын хэлбэр, түүний хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, нэгж эрхийн танилцуулга зэрэг мэдээлэлтэй танилцаж судалсны үндсэн дээр тухайн хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулах эсэх шийдвэрийг гаргадаг. Хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулалтын санд оруулсан хөрөнгийг өмчлөх эрхийг гэрчлэх нэрийн үнэт цаасыг "нэгж эрх" гэдэг. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх нь менежментийн компаниас гэрээнд тусгасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхийг олгодог, саналын эрхтэй, татан буулгах үед ногдох хөрөнгөө авах эрхийг гэрчилдэг боловч хөрөнгө оруулалтын сангийн аль нэг хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй. Учир нь Сангийн хөрөнгө оруулалтын багц нь олон тооны компанийн хувьцаа болон бусад санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг ба үр ашгийг өндөр байлгахын тулд менежерийн шийдвэрийн дагуу идэвхтэй арилжигддаг.


Хөрөнгө оруулалтын сангийн

хөрөнгийг тухайн сангийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгөөс тусгаарлан хадгалж, төлбөр, тооцоог гүйцэтгэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хөрөнгө оруулалтын сангийн гишүүдэд холбогдох мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээг эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг “кастодиан” гэнэ. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрсдэлийг хянахын тулд Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авсан кастодиануудын аль нэгийг сонгож хамтран ажиллах хуультай.

2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ БОЛОН БҮТЭЦ

Хөрөнгө оруулалтын сан нь хэлбэрийн хувьд хамтын болон хувийн гэсэн 2 хэлбэртэй бөгөөд төрлийн хувьд хамтын хөрөнгө оруулалтын сангийн хувьд нээлттэй болон хаалттай, хувийн хөрөнгө оруулалтын сангийн хувьд компанийн бүтэцтэй болон гэрээний бүтэцтэй ажилладаг төрлүүд байдаг.

Зураг 1 Хөрөнгө оруулалтын сангийн хэлбэр, төрөл



Хамтын хөрөнгө оруулалтын сан гол онцлог нь олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж эрсдэлийг аль болгох бага байлгаж жижиг хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс хөрөнгө оруулах арга хэрэгслүүдийг хуулиар тогтоон үйл ажиллагаа, санхүүгийн байдалд нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос нарийн хяналт тавьдаг.

Хамтын нээлттэй сан нь нэгж эрхээ бусдад худалдахаар тогтмол санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг бөгөөд нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг бол хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан нь үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан олон нийтэд нэгж эрхээ санал болгох замаар үнэт цаас гаргаж, нэгж эрхийг нэрлэсэн үнээр худалддаг, гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй онцлогтой сан юм. Тодруулбал хамтын хаалттай сангийн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа сангаас гаргах нөхцөлд нэгж эрхээ гуравдагч этгээдэд Хөрөнгийн Биржээр дамжуулан тухайн үед тогтсон үнээр худалдах бол нээлттэй санд хөрөнгө оруулагч нь сангийн хөрөнгийн тухайн үеийн үнэ цэнээр хөрөнгө оруулалтын сандаа буцаан худалдах эрхтэй гэсэн үг. Монгол улсад Хамтын хөрөнгө оруулалтын санг 10 хүртэлх жилийн хугацаатай үүсгэн байгуулж байна.

Хувийн хөрөнгө оруулалтын сан нь цөөн тооны мэргэжлийн гэгдэх (зохицуулах байгууллагаас тогтоосон) хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татан төвлөрүүлж, тус хөрөнгөөр Үнэт цаасны зах зээлд буй бүх хөрөнгө оруулалтын хэрэгсэл болон биржийн гадуурх ХХК-иудад хөрөнгө оруулалт хийх боломжтой. Энэ утгаараа эрсдэл, өгөөжийн төвшин хамтын сангаас өөр бөгөөд, зохицуулах байгууллагын хяналт харьцангуй хязгаарлагдмал байдаг.

Нэгж эрхийн тоо тогтмол гэдэг нь Сангийн

Хүснэгт 1 Хөрөнгө оруулалтын сангийн төрлүүд

	Хаалттай сан	Нээлттэй сан	Биржээр арилждаг сан /ETF/
Нэгж эрхийн тоо	Тогтмол	Хөвөгч	Хөвөгч
Үнэлгээ	Зах зээлийн үнэ	NAV буюу цэвэр хөрөнгийн үнэлгээг өдөр бүр хийдэг	Анхдагч зах зээл NAV Хоердогч зах зээл Зах зээлийн үнэ
Хөрвөх чадвар	Сараар эсвэл улирлаар	Сараар эсвэл улирлаар	Өдөр бүр
Багцын мэдээлэл	МХБ дээр арилжих	Өдрийн эцсийн үнэлгээгээр санд буцаан худалдах	Хоердогч зах зээл

анх гаргасан нэгж эрхийн тоо хэмжээнд өөрчлөлт оруулахгүй гэсэн утгатай. Харин нэгж эрхийн тоо хөвөгч гэдэг нь Сангийн анх гаргасан нэгж эрхийн тоон дээр хөрөнгө оруулагч шинэ хөрөнгө оруулалт хийх бүрд нэгж эрх нэмж гарган хэмжээ нь өсөж, харин хөрөнгө оруулалтаа татах бүрд гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авч тоо хэмжээ нь буурч байдаг төрөл юм.

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө

2.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2021 оны байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ Монгол Улсын санхүүгийн зах зээлийн нийт активын 12 хувийг эзэлж байгаа нь нийт арилжааны банкны активтай харьцуулахад 6.9 дахин бага байна. 2018 онд хөрөнгийн зах зээл санхүүгийн салбарын 8 хувийг эзэлж байсан бол сүүлийн 2-3 жилийн зах зээлийн идэвхжлийн нөлөөгөөр эзлэх хувь хэмжээ нь 4 нэгж хувиар өсжээ. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.98 их наяд төгрөгт хүрсэн нь 2021 оны ДНБ-ий 15 хувьтай тэнцэж, өмнөх оны мөн үеэс 2.95 их наяд төгрөгөөр буюу бараг хоёр дахин өссөн байна. Монголын хөрөнгийн биржийн TOP-20 индекс 2021 оны 12 дүгээр сарын 31-ний өдөр 44,411.6 нэгж үзүүлэлттэй гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 25,125.8 нэгжээр буюу 2.3 мөн дахин өсжээ.

Монгол улсад 2022 оны 3 сарын

оруулалтын сан нь хамтын нээлттэй сан болохын хувьд дээр үзүүлсэнчлэн өдөр бүр Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээг хийх бөгөөд, хэрхэн тооцох аргачлалыг энэхүү танилцуулгын хөрөнгө оруулалтын хэсгээс болон Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, Сангийн цэвэр активыг үнэлэх журам зэргээс дэлгэрэнгүй танилцана уу.

байдлаар “Үндэсний Хувьчлалын Сан” болон “Мандал Ирээдүйн Өсөлт” гэсэн 2 хамтын, хаалттай сан Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэн, үйл ажиллагаагаа явуулж байна.

2021 онд УИХ-аас Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр системийн нөлөө бүхий арилжааны банкнууд хувьцаат компанийн хэлбэрт шилжих төлөвлөгөөг Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банканд хүргүүлээд байгаа нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд тоон болон чанарын томоохон өөрчлөлт авчрах боломжийг бүрдүүлж байна.

Хөрөнгийн зах зээл хөгжих, оролцогч талууд, хөрөнгө оруулагч нар ихсэх тусам уг салбар дахь мэргэжлийн хөрөнгө оруулалтын институцийн оролцоо нэмэгдэх шаардлагатай болж байна. “Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан нь Монгол улсад харьцангуй шинэ ойлголт, туршлага



болох хамтын нээлттэй сангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах юм. Ингэснээр одоо байгаа 2 сантай харьцуулахад Хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын шинэ сонголт, шинэ боломж, илүү сайн хөрвөх

чадвар, хөрөнгө оруулалтын үнэ цэнийг илүү ойр давтамжтай хянах боломжийг хөрөнгө оруулагчдад бий болгоно гэж үзэж байна.

2.4 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол улсын "Хөрөнгө Оруулалтын Сангийн Тухай" хууль нь 2013 онд батлагдсан. Тус хууль батлагдсанаас хойш өдийг хүртэл Монгол улсад 2 хамтын хөрөнгө оруулалтын сан, 19 хувийн хөрөнгө оруулалтын сан бүртгэгдэн, үйл ажиллагаа эрхэлж байна. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд зааснаар Хөрөнгө оруулалтын сан нь хэлбэрийн хувьд хамтын эсхүл хувийн, харин төрлийн хувьд хаалттай болон нээлттэй байж болно. ҮЦЗЗ Тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, СЗХ-ны Хуульд заасан хөрөнгө оруулалтын сангийн эрсдэлийг багасгах, эрх ашгийг хамгаалах, сангийн үйл ажиллагааг хууль, түүнтэй холбогдон гарсан дүрэм журмуудад нийцүүлсэн зохицуулалтуудаас дурдвал:

1. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн чадавхын талаарх заалтууд:

1.1 Хөрөнгө оруулалтын сангийн нийт активын 5-аас доошгүй хувийн хөрөнгийг уг санг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани бүрдүүлж байх

1.2 Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагууд, менежерүүд болон үйл ажиллагааг явуулах мэргэжилтнүүд нь үнэт цаасны зах зээлд ажилласан туршлагатай, тухайн салбарт ажиллах явцдаа ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй, тэдгээр төрлийн гэмт хэрэгт холбогдож ял шийтгэл эдлээгүй, байх

1.3 Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гүйцэтгэх

удирдлага, сангийн менежер, үйл ажиллагаа явуулах мэргэжилтнүүд нь үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулах эрхийн үнэмлэхтэй байх гэх мэт

2. Хамтын хөрөнгө оруулалтын сангуудын хөрөнгө оруулах боломжтой хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг хязгаарлан тодорхой зааж өгсөн:

2.1 Засгийн газрын өрийн хэрэгсэл

2.2 Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл

2.3 Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа

2.4 Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл

2.5 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

3. Хөрөнгө оруулалтын эрсдэлийг хязгаарлах зорилгоор: Хөрөнгө оруулалтын нэг хэрэгсэлд хөрөнгө оруулах мөнгөн дүн болон хөрөнгө оруулалтын нийт активд эзлэх эдийн засгийн нэг салбарын болон нэг үнэт цаас гаргагчид оруулах хувь хэмжээнд хязгаар тогтоосон. Үүнд:

3.1 Эдийн засгийн нэг салбарт хөрөнгө оруулах дээд хязгаар нь сангийн нийт активын 25 хувиас хэтрэхгүй байна.

3.2 Тухайн сангийн нийт активын 10 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг 1 үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасанд оруулахыг хориглоно.

3.3 Аливаа хуулийн этгээдийн нийт

гаргасан үнэт цаасны 10 болон түүнээс дээш хувийн үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх буюу нийт саналын эрхийн 10 ба түүнээс дээш хувийг дангаар эзэмшихийг хориглоно.

Үүнээс гадна хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд хориглох зүйлс, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа болон хөрөнгийн менежментийн компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулалт

хийх олон талын төрийн болон хөндлөнгийн байгууллагын эрх үүрэг, үйл ажиллагааг журамлаж өгсөн. Хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгийн менежментийн компани нь үйл ажиллагаандаа дор дурдсан хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм журмуудыг баримталж ажиллана:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013)
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай (2013)
- Компанийн тухай хууль (2011)
- Аудитын тухай хууль (2015)
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль (2015)
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013)
- Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам (2014)
- Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам (2014)
- Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам (2014)
- Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар (2015)
- Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар (2016)
- Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох журам (2016)
- Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн мэргэжлийн үйл ажиллагааны болон ажилтны ёс зүйн дүрэм

Хөрөнгө оруулалтын сан нь дээрх хууль тогтоомж, журмаар тогтоосон шалгуурыг бүрэн хангасны үндсэн дээр тусгай зөвшөөрөл авдаг бөгөөд төрийн зохицуулах байгууллага, хяналтын байгууллага,

бүртгэлийн байгууллага болон хөндлөнгийн хяналт, үнэлгээний олон байгууллагын зохицуулалт, хяналт, шаардлагыг ханган ажиллах зохицуулалт бүхий хуулийн этгээд байна.

2.5 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.5.1 Гадаад зах зээл

Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор эдийн засаг, санхүүгийн зах зээлд олон өөрчлөлтүүд гарч байна. Хэдэн арван жил үүсэж бий болсон эдийн засгийн системүүд богино хугацаанд үндсээрээ өөрчлөгдөж байна. Энэ бүх өөрчлөлтийн нөлөөг багасгах зорилгоор 2020-2021 онуудад улс орнуудын Засгийн газрууд төсөв, мөнгөний бодлогоор дамжуулан 16 их наяд ам.долларын арга хэмжээ авсны үр дүнд дэлхийн эдийн засаг сэргэж эхлэв.

Гэвч энэ арга хэмжээг удаан авах боломжгүй бөгөөд дэлхийн улсуудын 80 гаруй хувь нь төсөв мөнгөний бодлогоо буцаан хумьж эхэлсэн байна. 2020 онд огцом унаад байсан эдийн засаг 2021 онд сэргэж, дэлхийн ихэнх улсуудад вакцинжуулалт идэвхтэй явагдсан нь сайн мэдээ. Гэвч Коронавирусын шинэ хувилбаруудын тархалт, Украин дахь ОХУ-ын хадлагаас үүдэлтэй энергийн тасалдал, нийлүүлэлтийн сүлжээний доголдол гээд 2022 он төсөөлж байсан шиг сайхан

эхэлсэнгүй. Ийнхүү Дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, 2022-2023 онуудад харгалзан 2.9% болон 2.7% болж буурахаар

байгаа бөгөөд дунд болон бага орлоготой орнуудад стагфляци үүсэх эрсдэл бий болоод байна.

Хүснэгт 2 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

№	Эх сурвалжууд	Төсөөлөл хийсэн хугацаа	2022 он					
			Дэлхий	Хөгжиж буй орнууд	Хятад	АНУ	Орос	Япон
1	Дэлхийн банк	2022.07	2.7%	3.4%	4.3%	2.5%	-8.9%	1.7%
2	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага	2022.06	3.0%	3.3%	4.4%	2.5%	-10.0%	1.7%
3	Олон улсын валютын сан	2022.04	3.6%	3.8%	4.4%	3.7%	-8.5%	2.4%


Хөгжиж буй орнуудын хувьд инфляцын өндөртөвшин, мөнгөний хатуубодлогохувийн хэрэглээнд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн өсөлт удааширахтай хавсран стагфляци үүсгэх төлөвтэй байна. Түүнчлэн хөгжингүй орнуудын эрэлтэд төдийлөн өөрчлөлт орохгүй, газрын тосноос бусад түүхий эдийн экспортын үнэ буурснаар хөгжиж буй орнуудын хувьд гадаад зах зээлийн нөхцөл байдал таагүй байхаар байна. Дэлхийн банк тогтвортой хөгжлийг хангахын тулд хөгжиж буй улсуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Глобал хамтын ажиллагаа гэх төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

1. Бодит Дотоодын нийт бүтээгдэхүүн

2020 онд 3.4% болтлоо агшаад байсан бодит ДНБ өсөлт 2021 онд 5.6% болж өссөнөөр эдийн засгийн талаарх эерэг хүлээлтийг үүсгээд байсан. Тэгтэл Дэлхийн банк 2022 оны эдийн засгийн өсөлтийг мөн л удааширч 2.7% болж буурна гэж мэдээллээ.

Зурар 2 Дэлхийн ДНБ-ий өсөлт /тэрбум, ам.долл./, www.statista.com

■ Дэлхийн ДНБ / тэрбум, ам.доллар /




2. Инфляц

Ковид-19 ийн нөхцөл байдалд Төв банкнууд үнийг хянах, нөгөө талдаа эдийн засгийн өсөлтийг хангах гэдэг 2 том шалгууртай нүүр тулаад байна. 2022 оны 6 сарын байдлаар дэлхий нийтийн инфляц бүх төсөөллийг даван өслөө. Нийлүүлэлтийн хомстлоос эрэлт их байгаагаар тайлбарлагдана. Эрчим хүчний үнийн өсөлт, нийлүүлэлтийн сүлжээний гацаа зэргээс инфляцын өсөлт илүү их цар хүрээг хамарч байна. Тээвэрлэлт, нийлүүлэлтийн хомстолтой холбоотойгоор АНУ-д гэхэд л 1982 оноос хойш байгаагүй өндөр 9.1% ийн инфляц, Европид 5.6%, Японд 2.5%, Хятадад 2.5%, Орос 15.9% ийн инфляц тус тус ажиглагдаж байна.

3. Орос, Украины зөрчилдөөн

Цар тахлын шокноосоо гарч амжаагүй байтал Орос, Украины нөхцөл байдал маш их эрсдэлийг дэлхийн эдийн засагт авчирч байна. Энэ нь цар тахлаас болж бий болсон өндөр инфляц, санхүүгийн салбар дахь савалгаатай байдал зэргийг улам дордуулах нь ойлгомжтой. Тухайлбал, эрчим хүч тэр дундаа, газрын тосны үнэ 2014 оноос хойш анх удаа 100\$ -ийг давсан бол Европын байгалийн хийн үнэ 62%-иар өссөн байна. Энэ нь Оросын эрчим хүч, хийн түлшний гол импортлогч болох Европын улсуудад хүнд нөлөөлнө. Мөн хүмүүс орлогынхоо ихэнх хувийг шатахуун, халаалтад ашиглах хандлагатай байгаа тул бусад хэрэглээ дагаад багасна гэсэн үг юм.



Bloomberg economics Орос, Украины зөрчилдөөний эдийн засагт үзүүлэх нөлөөг маш их, дунд, бага гэсэн хувилбараар төсөөлсөн байна.

- Хамгийн муудаа: Орос эрчим хүч болон хийн түлш нийлүүлэхээ зогсоох нь учирч болзошгүй хамгийн муу дүр зураг юм. Европт эрчим хүчний хомстол бий болж, цаашлаад эдийн засгийн уналт ажиглагдаж байгаа бол Европын хөгжлийн эдийн засгийн өсөлтөд томоохон цохилт өгч, бодлогын хүү нэмэгдэж болзошгүй.

- Дунджидаа: Оросуудад өгөх Баруун Европын хоригоос болж газрын тос, хийн түлшний хомстол бий болж болохоор харагдаж байна. Энэ нь Европын төв банканд илүү нөлөө үзүүлнэ.

- Хамгийн сайндаа: Талууд харилцан зөвшилцөлд хүрч чадвал, газрын тос болон эрчим хүчний үнийн хэт өсөлтийг сааруулж, АНУ болон Европын эдийн засгийн сэргэлт хэвийн байдалдаа эргэн орно.

Ямар ч дайны хор хохирлыг таамаглах боломжгүй байдаг. Тэгэхээр дээрх таамаглалаас илүү хор хохирлыг ч авчирч болзошгүй юм. Хэдий АНУ, Европ болон бусад улсуудад ирэх хохирол их ч Оросуудад энэ дайн нь илүү их сөрөг нөлөө авчрах нь мэдээж.

Хүмүүсийн амьдралд хамгийн их нөлөө үзүүлэх өөрчлөлт бол наад захын хэрэгцээг хангахад маш үнэтэй болох юм. Тухайлбал, гэрээ дулаацуулахад, ипотекийн зээлийн үнэ буюу хүү, мөн машины үнэ ч өсөх магадлалтай.

4. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээл **Зэс**

Зэсийг тоног төхөөрөмж, барилга, эрчим хүч, тээвэр гээд маш олон салбарт хэрэглэгддэг хязгааргүй хэрэглээтэй түүхий эд юм. Ялангуяа сүүлийн жилүүдэд цахилгаан машины үйлдвэрлэл ихсэж байгаатай холбогдуулан зэсийг "шинэ газрын тос" гэж ч нэрлээд буй. Ихэнх улс орнуудад вакцинжуулалт үр дүнтэй үргэлжилж, дэлхийн эдийн засаг сэргэж эхэлсэн зэрэгтэй холбоотой зэсийн үнэ 2021 оны 5 сард түүхэн дээд төвшинд хүрч \$4.9-т хүрээд байсан.

Зураг 4 Зэсийн үнэ /ам доллар/, www.tradingeconomics.com




Гэсэн хэдий ч БНХАУ-ын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хэд хэдэн удаагийн хөл хорионы улмаас эдийн засгийн өсөлт удааширч, үйлдвэрлэлийн гаралтай эрэлт багасаж улмаар \$3.3-т хүрээд байна.

Төмрийн хүдэр

2021 оны 5 сард төмрийн хүдрийн үнэ \$229.50/1 тонн хүрч мөн л түүхэн өндөр өсөлтийг үзүүлсэн байдаг. Энэ нь БНХАУ барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлтийн улмаас төмрийн хүдрийн эрэлт

НЭМЭГДСЭНТЭЙ ХОЛБООТО

Зураг 5 Төмрийн хүдрийн үнэ /ам доллар/,
www.tradingeconomics.com




2022 он гарсанаас хойш 17.67% нэмэгдэж \$136.50 хүрээд байсан хэдий ч одоогийн зах зээлийн үнэ \$100.5 байна. ОХУ болон Украин улсууд нь төмрийн хүдрийн томоохон үйлдвэрлэгчид юм. Энэ оныг дуусахад үнэ \$116.49 дээр хаагдана гэж шинжээчид таамаглажээ.

Алт

Алтын зах зээлийн үнэ эдийн засгийн тогтворгүй байдалд өсөж байдаг. Учир нь эдийн засаг унаж эхэллээ гэхэд алт нь бодит үнэ цэнэтэй учир хамгийн аюулгүй хөрөнгө оруулалтын хэрэгсэл болдог, нөгөө талаар таваар болон валютын шинжийг зэрэг агуулдаг онцлогтой бүтээгдэхүүн юм. 2020 оны 8 сард алтын ханш \$2074.88/1 унц болж түүхэн өндөр ханшийг тогтоосон. Энэ нь цар тахалтай холбоотой эдийн засгийн тодорхойгүй байдлаас үүдсэн эрэлтийн гаралтай өсөлт юм.

Зураг 6 Нэг унц алтын үнэ /ам доллар/, www.tradingeconomics.com




Өнөөдрийн байдлаар 1 унц алтын ханш \$1716.1 орчим байгаа бөгөөд 2022 он гарснаас хойш 4.5% унасан үзэгдэл юм. Үүнд мэдээж дэлхийн инфляц, АНУ-ын бодлогын хүүгийн өсөлт болон эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж эхэлсэн Орос Украины асуудалтай холбоотой.


Газрын тос

Газрын тосны хувьд санхүүгийн хямрал болсон 2008 оны 7 сард \$147.27/1 баррель хүрч хамгийн өндөр ханшиндаа хүрч байжээ. АНУ-аас эхлүүлээд дэлхийн бусад улсууд Орос улсад гадаад төлбөр тооцоо, худалдааны хориггоос эхлээд төрөл бүрээр хориг тавьж эхлээд байгаа билээ.

баррель газрын тосны үнэ /ам доллар/, www.tradingeconomics.com



Орос нь газрын тосны 3 дахь том экспортлогч бөгөөд Орос газрын тос нийлүүлэхээ больсноор эрэлт хэрэгцээ өндөр байгаа өнөөгийн нөхцөлд үнийг нэмэгдүүлэх нь тодорхой юм. Өнөөдрийн байдлаар сүүлийн 8 жилд байгаагүй дээд үнэ болох \$98.5-ийн ханштай байна.



2.5.2 Дотоод зах зээл

Манай улсын хувьд цар тахлын үед засгийн газраас хэрэгжүүлсэн багц арга хэмжээний үр дүнд зээл олголт сэргэж, улмаар эдийн засагт орох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар дотоодын эрэлтийг нэмэгдүүлсэн. Эдийн засаг том дүнгээрээ сэргэж буй мэт боловч олон салбарт хямралын сөрөг нөлөө үргэлжлэн ажилгүйдэл, ядууралд нөлөөлөх эрсдэл хэвээр байна. Цаашид эдийн засгийн өсөлтийн бааз суурь хүмигдсан, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж мүү буюу жигд бус, боловсролын чанарын ялгаа өндөр, санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалттай төвшинд хүрээгүй буюу гүнзгийрүүлэн сайжруулах шаардлагатай, тогтвортой хөгжлийн асуудал тулгамдсан хэвээр байгаа зэрэг сорилтууд Монгол Улсын эдийн засгийн өмнө тулгарч буйг олон улсын байгууллагууд онцолжээ. Улсын төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийн суурь тогтолцоо сул байгаа нь эдийн засгийн хөгжилд саад учруулж байгааг Азийн Хөгжлийн Банкны "Хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн үнэлгээ"-нд дурджээ (АХБ, 2021). Орлогын төсөөллүүд хэт өөдрөг хийгддэгээс төсвийн тодотголууд жилийн явцад ойр ойр хийгдэх, төсвийн тэнцлийн зорилтууд байнга зөрчигдөх байдал хэвийн болсны дээр зарлагыг хянах танах, төсвийн бодлогыг эдийн засгийн савлагаанд илүү дархлаатай болгох тал дээр авч хэрэгжүүлж буй зөв алхмуудад төсвийн гадуурх зарцуулалт садаа болж ирлээ.

Засгийн газраас 2022 онд хөгжлийн төслүүдийг эхлүүлэх, хүртээмжтэй өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих замаар эдийн засгийг сэргээх шинэчлэл хийнэ хэмээн мэдэгдээд буй. Энэ хүрээнд "Шинэ сэргэлтийн бодлого" хэмээх эдийн засгийн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулж 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хурал (УИХ)-аас батлаад байна.

Монгол улс нь Оросоос цахилгаан эрчим хүч, нефть авахаас гадна улаан буудай, ургамлын тос зэрэг өргөн хэрэглээний бүтээгдэхүүнүүдийг импортоор авдаг. Гаднаас импортоор авдаг бараа бүтээгдэхүүний 30 гаруй хувийг ОХУ-аас оруулж ирдэг гэсэн үг. Тиймээс Орос Украины нөхцөл байдал манай

улсын эдийн засагт цаашдаа сөрөг нөлөө үзүүлж тодорхойгүй байдал үргэлжлэх төлөвтэй байна.

Нөгөө талаас БНХАУ-ын эдийн засаг сэргэж буйтай холбоотойгоор манай улсаас авах таваарын эрэлт өндөр байж зэс, нүүрс зэрэг манай улсын гол экспортын бүтээгдэхүүний үнэ цаашид өсөх хандлагатай байгаа нь хилийн боомт, тээвэрлэлтийн асуудлаа шийдвэрлэж чадвал Монгол Улс үйлдвэрлэл, экспортын орлогоо нэмэгдүүлэх, төгрөгийн тогтвортой байдлыг хангах боломж буй гэж үзэхэд хүргэж байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн


Дэлхийн эдийн засгийн өсөлт саарч байсан 2020 онтой харьцуулахад 2021 онд Монгол Улсын эдийн засаг сэргэн ДНБ 1.4 хувиар өссөн байна. 2021 оны эхний хагас жилд ажиглагдсан эдийн засгийн сэргэлт нь хоёрдугаар хагаст импортоор орж ирдэг үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлтийн саатал, түүхий эдийн экспортын тасалдал зэргээс шалтгаалан саарчээ. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд цар тахлаас үүдэлтэй гэнэтийн шок Монгол Улсын эдийн засгийн өрөөсгөл бүтцийн сул талыг улам бүр тодруулсан.

Ажүйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 18,537.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 11.0 хувиар буюу 1,784.2 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд энэхүү өсөлтөд уул уурхай, олборлох (698.0 тэрбум төгрөг) болон боловсруулах үйлдвэрлэл (932.7 тэрбум төгрөг)-ийн салбарын өсөлт голлон нөлөөлжээ. Өсөлтийн ихэнх хувийг уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар эзэлж, бусад салбарын өсөлт бага байна.

Мөн дээр дурдсан хөрөнгө оруулалтын орчинг харвал эдийн засагт инфляц өндөр хэвээр хадгалагдах төлөвтэй байгаа бөгөөд Орос, Украины улс төрийн тогтворгүй нөхцөл байдлаас улбаалж олон улсын эдийн засаг тэр дундаа хөрөнгийн зах зээл хүлээлтийн байдалтай байна. Нөгөө талаас таваарын зах зээлийн үнийн өсөлт өндөр байгаа нь манай улс уул уурхайн бүтээгдэхүүнээ нийлүүлж л чадвал дотоодын эдийн засагт сэргэлт авчрахаар харагдаж байна. Уул

уурхайн салбар манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, экспортын 93 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 хувийг тус тус бүрдүүлдэг. Тус салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг, үзүүлэх нөлөө жилээс жилд тэлж, томорсон хэвээр байна. Монгол улсын гадаад валютын нөөцийг бүрдүүлдэг зэс, нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ ханш өсөж байгаа хэдий ч Олон улсад бий болоод буй нийлүүлэлтийн сүлжээний гацаанаас үүдэн эдийн засгийн өсөл удааширч 2.5 орчим хувийн өсөлт үзүүлэх боломжтой харагдаж байна.

Зураг 10 Эдийн засгийн өсөлтийн таамаглал



Эх сурвалж: www.worldbank.org, www.adb.org

Мөнгөний нийлүүлэлт

Монгол банкны 2021 оны 12 дугаар сарын статистик мэдээллээр мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс 14.78 хувиар өсөж 27.8 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 6.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 9.1 нэгж хувийг төгрөгийн харилцах, 0.4 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, 1.5 нэгж хувийг гадаад валютын харилцах, -2.8 нэгж хувийг гадаад валютын хадгаламж тус тус бүрдүүлж байна. Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 3.2 хувиар өсөхөд иргэд, хувийн байгууллагын төгрөгийн харилцах болон төгрөгийн хадгаламж өссөн нь нөлөөлжээ.

Инфляц

2021 оны 12 дугаар сарын байдлаар сарын инфляц 2.1 хувь, жилийн 13.4 хувь байсан. Гэтэл 2022 оны 6 сарын байдлаар улсын

инфляц 15.1% болж 22%-иар өслөө. Украин дахь ОХУ-ын халдлагын улмаас газрын тос шатахууны үнэ огцом өсөж, БНХАУ дахь худа дараа хөл хорионоос үүдэлтэй түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээний доголдол зэрэг нь манай орны инфляцад шууд нөлөө үзүүлж, өсөлтийг авч ирэв.

Валютын ханш

Сүүлийн жилүүдэд цар тахалтай холбоотойгоор импортын хэрэглээ харьцангуй бага, ам.долларын ханшийг тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлсэнийн үр дүнд төгрөгийн доллартай харьцах ханш тогтвортой байсан. 2022 оноос манай улс улбар шар төвшнөөс шар төвшин рүү шилжиж хил нээгдэн, хүмүүсийн хэрэглээ нэмэгдсэн, нөгөө талдаа түүхий эд тэр дундаа газрын тосны үнэ нэмэгдсэнээр ам.долларын нөөцийн гадагшлах урсгал огцом ихэссэн бөгөөд нөгөө талдаа экспорт тэр төсөөлсөн хэмжээгээр нэмэгдэж чадаагүйн улмаас төгрөгийн доллартай харьцах ханш суларч 1ам.доллар 3150 төгрөг болоод байна.

2.5.3 Хөрөнгийн биржийн өнөөгийн нөхцөл байдал

Хөрөнгийн зах зээл

2021 онд Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.8 их наяд төгрөгт хүрч, ТОП-20 индекс өнгөрсөн оноос 121%-иар өссөн нь дэлхийн хөрөнгийн зах зээлд Монгол улс хамгийн өндөр өсөлттэй зах зээл болж чадсан. Үүнд Төв банкны бодлогын хүү 6 хувь хүртэл буурснаар арилжааны банкнуудын хадгаламжийн хүү огцом буурсан, цартахлын эсрэг төр засгийн хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд хугацаатай хадгаламжийн хүүг тэглэсэн, валютын гадагшлах урсгал буурч импорт багассан зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан дотоодын хөрөнгө оруулагчид эрсдэл багатай, өгөөж өндөр альтернатив хөрөнгө оруулалтын боломжуудыг эрэлхийлж эхэлсэн нь хөрөнгийн захын хөгжлийг дэмжих чухал суурь хөшүүрэг болсон.


Гэсэн хэдий ч 2022 оны Энэ оны эхний 6 сарын байдлаар хөрөнгийн биржийн арилжааны идэвхи 30 хувиар буурч, Хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээ 4.8 их наяд болон буурав. Энэ нь эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлаас улбаалан хөрөнгө

оруулагчдын дунд хямралын айдас бий болсонтой холбоотой гэж шинжээчид үзэж байна.

Гэсэн хэдий ч Банкны тухай хууль батлагдаж арилжааны банкнууд хувьцаагаа олон нийтэд санал болгох ажил эхэлсэн, шинээр нэмэлт хувьцаа, 50 тэрбумын Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасзэрэг хэд хэдэн шинэ бүтээгдэхүүн гарч байгаа зэрэг нь Монголын хөрөнгийн зах зээл хөрөнгө оруулагчдын анхаарлыг татжээ.

2022 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжигдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 4 их наяд 839 тэрбум төгрөг байгаа нь оны эхэн үеэс 16.6 хувь буурсан үзүүлэлттэй гарчээ.

Зураг 11 МХБ-ийн зах зээлийн үнэлгээ /тэрбум/



Эх сурвалж: www.mse.mn

Индексүүдийн хувьд 2021 онд өмнөх оны мөн үеэс ТОП-20 индекс 130 хувь, MSE A индекс 70 хувь, MSE B индекс 63 хувиар тус тус өссөн үзүүлэлтүүдтэй байна.

Зураг 12 МХБ-ийн топ 20, MSE A, MSE B индексийн ханш



Эх сурвалж: www.mse.mn

Арилжаа

Энэ оны эхний 6 сарын байдлаар үнэт цаасны хоёрдогч зах зээл дээр 1141.2 тэрбумын арилжаа явагдлаа. Үүний 45% нь хувьцааны энгийн, 35.4% нь хувьцааны багцын, 15.7% нь бондын, үлдсэн нь ХБҮЦ болон ХОС-гийн арилжаа байв. Энгийн хувьцааны арилжаа 6-р сард ердөө 3.2 тэрбум байсан нь оны эхнээс 91%, өнгөрсөн оны мөн үеэс 53% тус тус унаснаар арилжааны идэвх буурсныг илэрхийлэх аж.

Түүнчлэн ТОП-20 индекс оны эхнээс 25% унасан ба түүнийг бүрдүүлэх 20 компанийн 2 нь л буюу Максимпекс (ММХ), Талх Чихэр (ТСК)-ийн ханш оны эхнээс өсжээ. Бусад нь бүгд унасан бол хамгийн их буюу 63%-ийн уналтыг Ард Санхүүгийн Нэгдэл (AARD) үзүүлсэн байна.

Шинэ бүтээгдэхүүн

Хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах потенциал байвч бүтээгдэхүүний сонголт мүү байгаа талаар олон жил ярьж ирсэн. Тэгвэл 2019 оноос хойш Хөрөнгийн бирж дээрх шинэ бүтээгдэхүүний төрөл хэмжээ өссөөр 2021 онд л гэхэд 9 шинэ бүтээгдэхүүнийг санал болгосон билээ. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /Invescore/, 5.5 тэрбум төгрөг амжилттай босгож захиалга 116.5% биелэгдсэн.
- 3 компанийн Бонд /Lendmn, Invescore, Monpay/
- Мандал ирээдүйн өсөлт хөрөнгө оруулалтын сан /Мандал ассет менежмент/, 50 тэрбум төгрөгийг анхдагч зах зээл дээр босгосон.
- Хувьцаа /CU/, 40.1 тэрбум төгрөгийг босгож 160.7%-ийн гүйцэтгэлтэйгээр анхдагч арилжаа хаагдсан.
- Банкны салбарын анхны хувьцаа /Богд Банк/, Богд банк хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргаж IPO хийсэн анхны банк болсон. Нийт хөрөнгийнхөө 20 хувийг олон нийтэд нээлттэй болгож 33.2 тэрбумыг босгожээ.

Мөн 2022 онд Хөрөнгийн бирж дээр 3

шинэ бүтээгдэхүүн гарсан байна.

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас / Simple/, Зээлийн аппликэшн болох Симпл ердөө 3 хоногийн дотор 50 тэрбум төгрөг амжилттай босгож Хөрөнгийн зах зээлд шинэ амжилт тогтоов.

- Инвескор нэмэлт хувьцаа, IPO хийсэн ханшаас 3 жил тасралтгүй өссөн Инвескор компани 4 сая ширхэг нэмэлт хувьцаа гаргаж 16.6 тэрбум төгрөгийг анхдагч зах зээл дээр амжилттай босгов.

- Эрдэнэс Сольюшинс нэмэлт хувьцаа, Хөрөнгийн бирж дээр цөөн хэдэн технологийн компанийн нэг болох Эрдэнэс сольюшинс компани 16.6 сая ширхэг нэмэлт хувьцаа гаргаж 1.8 тэрбум төгрөгийг анхдагч зах зээл дээр амжилттай босгов.


2022 оны 6 сарын байдлаар хөрөнгийн зах зээл нь Монгол Улсын санхүүгийн зах зээлийн 12 хувийг эзэлж байгаа нь нийт арилжааны банкны активтай харьцуулахад 6.9 дахин бага байна. 2018 онд хөрөнгийн зах зээл санхүүгийн салбарын 8 хувийг эзэлж байсан бол зах зээлийн идэвхжлийн нөлөөгөөр санхүүгийн салбарт эзлэх хувь хэмжээ 4 хувиар өссөн байна. 2022 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 4.84 их наяд төгрөгт хүрсэн нь ДНБ-ий 13.6 хувьтай тэнцэж, оны эхэн үеэс 1 их наяд төгрөгөөр буюу 16.6 хувиар буурсан байна.

2021 онд УИХ-аас Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр системийн нөлөө бүхий арилжааны банкнууд хувьцаат компанийн хэлбэрт шилжих төлөвлөгөөг Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банканд хүргүүлээд байгаа нь 2022 оноос хөрөнгийн зах зээлийн хөгжилд тоон болон чанарын томоохон өөрчлөлт авчрах боломжийг бүрдүүлж байна.

Дээр дурдсан хөрөнгө оруулалтын орчинг харвал эдийн засагт инфляц өндөр хэвээр хадгалагдах төлөвтэй байгаа бөгөөд Орос Украины нөхцөл байдлаас улбаалж эдийн засаг тэр дундаа хөрөнгийн зах зээл хүлээлтийн байдалтай байна. Нөгөө талаас таваарын зах зээлийн үнийн өсөлт өндөр байгаа нь манай улс уул уурхайн

бүтээгдэхүүнээ нийлүүлж л чадвал дотоодын эдийн засагт сэргэлт авчрахаар харагдаж байна. Уул уурхайн салбар манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, экспортын 93 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 хувийг тус тус бүрдүүлдэг. Тус салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг, үзүүлэх нөлөө жилээс жилд тэлж, томорсон хэвээр.

Хөрөнгийн зах зээлийн идэвхи суларч, эдийн засгийн өсөлт удаашихаа хүлээлттэй байгаа энэ цаг үед хөрөнгө оруулалт хийх нь урт хугацаанд өсөлт бий болгох хөрөнгийг хямдралтай худалдан авах боломж билээ.



“АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА



3. “АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

СЭХ
2022 оор 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

3.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сангийн нэр	“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан
Сангийн регистрийн дугаар	6892752
Сангийн улсын бүртгэлийн дугаар	9011841358
Санг бүртгэсэн огноо	2022.7.18
Сангийн хэлбэр	Хамтын
Сангийн төрөл	Нээлттэй
Үйл ажиллагаа явуулах хугацаа	10 жил
Татан төвлөрүүлэх боломжит дээд дүн	150 тэрбум төгрөг хүртэлх
Нийтэд санал болгох нэгж эрхийн дээд хязгаар	500'000'000 /таван зуун сая/ ширхэг
Нэгж эрхийн нэрлэсэн үнэ	100 /нэг зуу/ төгрөг
Сангийн удирдлага	Нэгж эрх эзэмшигчдийн хурал
Хөрөнгө итгэмжлэн удирдах компани	“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК
Хөрөнгө хадгалах кастодиан	Голомт Банк ХХК
Хөрөнгө оруулалтын багц	Өсөлтийн багц Хувьцаа $\leq 70\%$; Өрийн хэрэгсэл $\leq 20\%$; Хадгаламж болон бэлэн мөнгө $\leq 10\%$
Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний үндсэн хөлс	Удирдаж буй хөрөнгийн хэмжээнээс (AUM): 2.2%
Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний бонус урамшуулал	Цэвэр активын хамгийн бага өгөөжөөс давсан өсөлтийн: 20%
Зорилтот өгөөж	15%
Нэгж эрхийн үнэ тогтох арга	Анхдагч арилжааны нэгж эрхийн үнэ Нэрлэсэн үнэ байна. Түүнээс хойш Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээн дээр үндэслэнэ.
Хөрвөх чадвар	Сан нь хөрөнгө оруулагчийн нэгж эрхийг буцаан худалдан авах үүрэг хүлээж, төлбөр гүйцэтгэнэ.
Арилжааг зохион байгуулах байгууллага	“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК Сангийн онлайн платформ
Холбоо барих	Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, 15174, Энхтайвны өргөн чөлөө, Сити тауэр, 1001 тоот Утас: 77661112 Имэйл: admin@ashidasset.mn



“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан нь Монгол улсын Хөрөнгө оруулалтын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмуудын дагуу үүсгэн байгуулагдаж, тэдгээрийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн эрхтэй, тусгай зохицуулалтын компани юм.

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан нь нэгж эрхээ олон нийтэд худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг, гаргасан нэгж эрхээ буцаан худалдан авах үүрэг хүлээдэг нээлттэй хамтын хөрөнгө оруулалтын сан юм.

“Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын сан нь 500'000'000 /таван зуун сая/ ширхэг зарласан нэгж эрхтэй байх бөгөөд Санг үүсгэн байгуулах баримт бичиг, нэгж эрхийн танилцуулгыг Хороонд бүртгүүлснээс хойш 3 сарын хугацаанд олон нийтэд танилцуулж, 1 сарын хугацаанд 10'000'000 /арван сая/ ширхэг нэгж эрхийг нэг бүрийг нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнээр анхдагч зах зээлийн арилжаанд гаргаж 1.0 /нэг/ тэрбум төгрөг татан төвлөрүүлж, тусгай зөвшөөрөл авснаар үйл ажиллагаагаа эхлүүлэх бөгөөд Сангийн үйл ажиллагаа явуулах хугацаанд нэгж эрхээ олон нийтэд худалдахаар байнга санал болгож эрэлтийн хэмжээгээр зарласан нэгж эрхээс худалдаанд гаргаж, хөрөнгө татан төвлөрүүлж ажиллана.

“Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулахыг хүсэж буй хөрөнгө оруулагч нар хэдийд ч Сангийн онлайн платформ болон гар утасны аппликэйшнээр дамжуулан эсхүл Сангийн төлөөлөгч нараас зөвлөгөө авч хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулан, нэгж эрх худалдан авах, хүлээлгийн хугацаа нь дууссан буюу буцаан худалдах хүчинтэй нэгж эрхээ Санд эргүүлэн худалдах боломжтой. Сангийн нэгж эрхийг буцаан худалдан авах үүргийн дагуу сангийн нийт удирдаж буй хөрөнгийн тодорхой хэсгийг хөрвөх чадвар сайтай бэлэн мөнгө, банкны хадгаламж болон засгийн газрын өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийж, сангийн хөрвөх чадварыг хангаж ажиллана.

3.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

3.2.1 Сангийн хөрөнгө оруулалтын зорилго, активын бүтэц

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалтын үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй, хялбар, хямд, хариуцлагатайгаар хүргэх замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг мэргэжлийн төвшинд удирдаж хөрөнгө оруулагчиддаа үр өгөөж хүртээх зорилготой Хамтын, нээлттэй хөрөнгө оруулалтын сан юм.

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан нь нэгж эрх эзэмшигчдийн эрх, ашгийг нэгдүгээрт тавьж, нэгж эрсдэлд ногдох өгөөж өндөртэй хувьцаа болон өрийн хэрэгсэл, хадгаламжийн бүтээгдэхүүнээр багцаа бүрдүүлж эрсдэл тооцсон өгөөж / risk-adjusted return/-ийг хамгийн өндөр байлгах аар зорьж ажиллана.

“Ашид Арвижих” хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан нь Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 200 дугаар тогтоолоор баталсан “Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох тухай журам”-ын 2.1.5-д заасны дагуу “Нийтлэг сан” бөгөөд тогтмол орлого бий болгох хөрөнгө оруулалт /income investing/ болон Өсөлтийн хөрөнгө оруулалт /growth investing/ стратегиудыг хослуулан хэрэглэнэ. Ингэснээр нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгө үнэ цэнийн хувьд урт хугацаанд тогтвортой өсөхөөс гадна богино хугацаанд хөрөнгө оруулалтаа эргэн таталгүйгээр тогтмол орлого хүртэх боломжтой болох юм.

Тогтмол орлого бий болгох стратегийн хувьд сан нь эрсдэл багатай, хөрвөх чадвар сайтай, тогтмол өгөөжтэй засгийн газар, нийслэл болон компанийн өрийн хэрэгслүүдэд сангийн удирдаж буй хөрөнгийн 20-30%-ийг хөрөнгө оруулна. Өсөлтийн стратегийн хувьд сангийн удирдаж буй хөрөнгийн 70 хүртэл хувийг дотоод, гадаадын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, эрсдэл тооцсон өгөөж хамгийн өндөртэй байхуйц, тогтвортой үйл ажиллагааны орлоготой, зах зээлд танигдсан компаниудын хувьцаанд голлох салбаруудаар төрөлжүүлэн хөрөнгө оруулна.

Гадаад зах зээлд оруулах хөрөнгө оруулалт нь дотоодын зах зээлийн эрсдэлээс хамгаалах (hedging) болон материал,

технологийн хөгжлийг түүчээлэгч тэргүүлэх компаниудын өсөлтөөс өгөөж хүртэх зорилготой байх тул ногдол ашиг тараадаг, зах зээлийн үнэлгээ, нэр хүнд сайтай (blue-chip) хувьцаануудыг сонгоно. Хөрөнгө оруулах дүнгийн хувьд сангийн удирдаж буй хөрөнгийн 30 хувь хүртэл байж болно.

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө

оруулалтын сан нь нээлттэй буюу нэгж эрхээ буцаан худалдан авах үүргийг нэгж эрх эзэмшигчийнхээ өмнө хүлээж байгаа тул сангийн хөрвөх чадвар, нэгж эрх буцаан зарах хүсэлтийг хангахын тулд сангийн удирдаж буй хөрөнгийн 10%-ийг бэлэн мөнгө болон банкны хугацаат хадгаламжид хөрөнгө оруулна.

Хүснэгт 3 Хөрөнгө оруулалтын багцын харьцаа


Хөрөнгө оруулалтын хэрэгсэл	Strategy	Багад эзлэх %	Зах зээл
Нээлттэй ХК-ийн хувьцаа	Growth investing	<70%	Дотоод, гадаад
Өрийн хэрэгсэл	Income investing	20<30%	Дотоод
Бэлэн мөнгө ба хадгаламж	Income investing	10%	

3.2.2 Модель багц ба багц боловсруулах аргачлал

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан нь нээлттэй ХК-ийн хувьцаа, компани болон засгийн газрын өрийн хэрэгсэл, богино хугацаат банкны хадгаламж, бэлэн мөнгө гэсэн хэрэгслүүдээр сангийн багцыг бүрдүүлнэ.

Бид Нобелийн шагналт, эдийн засагч Хэрри Маркович-ийн боловсруулсан Modern Portfolio Theory /MPT/ буюу орчин үеийн багц бүрдүүлэх онолын дагуу хоорондын хамаарал бага хувьцаанууд сонгож, эрсдэлийг тараан байршуулах замаар багцаа бүрдүүлнэ. MPT нь хүлээн зөвшөөрч болохуйц тодорхой эрсдэлийн төвшинд хамгийн өндөр өгөөжтэй байхаар хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн хэрэгслийг сонгох хамгийн шалгарсан арга юм. Мөн бид багцын нэгж эрсдэлд ногдох өгөөж /Sharpe ratio/-ийн хэмжээг хамгийн өндөр байлгах аргаар зорьж, багцаа хянаж, шаардлагатай тохиолдолд хянаж ажиллана. Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн хувьд яг ижил эрсдэл болон өгөөжтэй хэрэгслүүдээс сонгохдоо efficient frontier болон capital allocation line /CAL/ ашиглана.

Зураг 13 Efficient frontier and capital allocation line



Модель багцыг бүрдүүлэх тооцооллод хувьцааны хувьд Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, нээлттэй арилжаалагдаж буй нийт хувьцаат компаниудыг үйл ажиллагаа явуулж буй салбараар нь 5 үндсэн салбарт ангилж, 2012-2021 он дуусталх сүүлийн 10 жилийн түүхэн өгөгдөлд суурилж, салбар тус бүрийн болон тухайн салбарын хувьцаат компани тус бүрийн өгөөж, ногдол ашиг, тэдгээрийн эрсдэлийг харьцуулан судалсан. Тооцооллоос үзэхэд өнөөгийн байдлаар санхүүгийн салбар хамгийн өндөр, хүнс хөдөө аж ахуй болон дэд бүтцийн салбарууд түүний дараах үр ашигтай салбар болох нь харагдаж байна. Зохицуулалтын журмын дагуу хамтын сангийн хөрөнгө оруулалтын 25-аас их хувь эдийн засгийн нэг салбарт төвлөрч болохгүй тул бид хөрөнгө оруулалтынхаа 25 хувийг дотоодын санхүүгийн салбарт, 20 хувийг хүнс хөдөө аж ахуйн салбарт, 15 хувийг барилга, дэд бүтэц зэрэг бусад салбарын компаниудад хуваарилахаар төлөвлөж байна.

Харин гадаад зах зээлийн хувьцааны хувьд технологи, материал болон түүхий эдийн салбарт нэр хүндтэй, зах зээлийн үнэлгээ өндөртэй компаниудаас бүрдсэн NASDAQ Composite, S&P 500 GSCI, Dow Jones Industrial Average 30 зэрэг 3 индексийг жишиг болгон авч 2012-2021 он дуусталх 10 жилийн түүхэн өгөгдөлд суурилж, гадаад хувьцааны өгөөж болон ногдол ашиг, тэдгээрийн эрсдэлийг харьцуулан судалж нийт багцын 10 хувийг хуваарилж модель багцын өгөөжийг тооцоолов. Зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан дотоод, гадаад зах зээлийн хуваарилалтыг өөрчлөх боломжтой,

ингэхдээ гадаад хөрөнгө оруулалтын нийт дүн багцын 30 хувиас хэтрэхгүй байна.

Хүснэгт 4 Модель багц, багцын өгөөж, хувийн жин

Багцын мэдээлэл		Өгөөж				Жин	
Ангилал	Хөрөнгийн нэр	Валютын ханшийн нөлөө	Үнийн өсөлт	Ногдол ашиг	Нийт өгөөж	Хувийн	Бүлгийн
Дотоод хувьцаа	Санхүүгийн салбар	0%	3174%	3174%	3188%	25.0%	60%
	Хүнс, ХАА салбар	0%	20.43%	20.43%	23.28%	20.0%	
	Бусад салбар	0%	19.88%	19.88%	20.32%	15.0%	
Гадаад хувьцаа	Технологи, материал, түүхий эдийн салбар	9%	12.73%	12.73%	24.03%	10.0%	10%
Бонд, үнэт цаас	Засгийн газар, нийслэл, компанийн бонд	0%	0%	0%	15.0%	20.0%	20%
Бэлэн мөнгө	Хугацаатай хадгаламж	0%	0%	0%	6.7%	8.0%	10%
	Хугацаагүй хадгаламж	0%	0%	0%	3.0%	2.0%	
Нийт					21.67%	100.0%	100.0%

Тогтмол орлоготой өрийн хэрэгслийн хувьд сүүлийн жилүүдэд хөрөнгийн бирж болон биржээс гадуурх зах зээл дээр арилжаалагдаж байгаа компанийн бондын хүүг /coupon/ жишиг болгон авсан. Банкны хадгаламжийн бүтээгдэхүүний хувьд Монгол банкнаас гаргадаг банкнуудын хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн жигнэсэн дундаж хүүгийн төвшинг суурь болгон тооцсон.

Модель багцын хөрөнгө оруулах хэрэгсэл тус бүрийн хувийн жинг тооцохдоо оптимизацийн аргыг ашиглаж, багын эрсдэл тооцсон өгөөжийг хамгийн өндөр байлгахад бүрдүүлсэн.

3.2.3 Нээлттэй өмчлөлийн хэрэгсэлд

Хүснэгт 5 МХБ-ийн нээлттэй хувьцаат компаниудын өгөөж /он, салбараар/

Он	Санхүү	Хүнс, ХАА	Дэд бүтэц	Үйлдвэрлэл	Уул уурхай
2012	54.9%	-6.3%	-10.8%	0.0%	-17.1%
2013	-15.3%	11.7%	87.2%	61.0%	-23.1%
2014	71%	13%	4.3%	31.0%	-27.8%
2015	-9.5%	1.2%	-6.3%	20.0%	-31.5%
2016	-21.5%	5.2%	35.2%	3.0%	-15.3%
2017	85.6%	76.1%	26.0%	107.0%	201.9%
2018	91.4%	-11.5%	1.2%	36.0%	-16.5%
2019	-7.5%	6.1%	15.7%	-13.0%	-4.0%
2020	44.2%	66.9%	17%	-20.0%	39.1%
2021	39.3%	62.0%	49.1%	64.0%	8.0%
Дундаж өгөөж	26.9%	21.3%	20.3%	28.9%	11.4%
Стандарт хазайлт	39.8%	31.6%	28.7%	37.6%	66.5%

Тооцооллындагуу одоогийн байдлаарсанхүү, хүнс ХАА, дэд бүтцийн салбаруудын хувьцаат компаниудад эрсдэл тооцсон өгөөж /risk-adjusted return/-ийн хэмжээгээр хамгийн өндөр өгөөжтэй байна. Уг 3 салбарт сангийн удирдаж буй хөрөнгийн түс түс 28.5%, 3.5%, 38.0%-ийг, нийт 70%-ийг хөрөнгө оруулна. Үйлдвэрлэл болон Уул уурхайн салбарын хувьцаат компаниудын хувьд өсөлт гаргах, үйл ажиллагаа нь сайжрах, зах зээл нь илүү тэлэх тохиолдол гарвал тухай бүрд нь багцаа ахин оптимизаци хийж сангийн удирдаж буй багцад нэмэх боломжтой.

Салбар бүрийн тухайлсан хувьцаат компанийг сонгохдоо цаашид өсөх боломжтой, зах зээл нь өсөх төлөвтэй, тогтвортой мөнгөн урсгалтай компаниудад төвлөрөн хөрөнгө оруулна. Хувьцаат компани нэг бүрийг үнэлэхдээ дараах үзүүлэлтүүдэд үндэслэнэ. Үүнд:

- Салбарын шинжилгээ. Аливаа хувьцаат компанийг үнэлэхээс өмнө тухайн салбарын бизнес, түүний онцлог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хэрэглэгчид нь хэн бэ гэх зэрэг салбарын нийтлэг судалгааг нэгдүгээрт хийж, уг салбар өсөх потенциал байгаа эсэхийг нягталж үзэх нь чухал.

- Санхүүгийн үзүүлэлтүүд. Тухайн хувьцаат компанийн тайлангийн үзүүлэлтүүд тогтвортой, хөшүүрэг болон бусад эрсдэл багатай, ашиг нь тогтмол өсөж байгаа, эерэг мөнгөн урсгалтай байх.

- Удирдлага, менежментийн баг. Аливаа бизнес, байгууллагын амжилт, өсөлт нь ажиллаж буй хүмүүс, тэдгээрийн боловсрол, менежментийн арга барил зэргээс шууд хамаардаг. Мөн хувьцаат компанийн хувьд менежментийн баг, удирдлагууд нь ажлын ур чадвараас гадна хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үүний төлөө шийдвэр гаргах хандлага болон ёс зүйн хувьд итгэж болохуйц, ёс зүйн аливаа доголдолгүй байх ёстой.

- Өрсөлдөгчид. Тухайн хувьцаат компанийн зах зээлд эзлэх одоогийн байр суурь, хэрхэн өөрчлөгдөж байгаа тухай болон бусад өрсөлдөгчид, тэдгээрийн чадавх, зах зээлийн байр суурийг үнэлснээр тухайн хувьцаат компанийг илүү бодитой үнэлэх боломжтой.

Эдгээр хүчин зүйлүүдийг үндэслэн компанийн бодит үнэлгээг хийх бөгөөд

зах зээлийн ханш нь бодитой үнээр арилжаалагдаж байгаа компанийг багцаа сонгоно. Мөн түүнчлэн худалдан авсан компанийн хувьцаа эзэмшигчийн хувьд шийдвэр гаргалтуудад нөлөөлж үйл ажиллагааг сайжруулах, компанийн орлого нэмэгдэж, ашгийн төвшинг нэмэгдүүлэх замаар сангийн нэгж эрх эзэмшигчдийн өгөөжийн нэмэгдүүлэхээр ажиллана.

3.2.4 Засгийн газар, нийслэл, компанийн өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах стратеги

Засгийн газар, нийслэл, компанийн өрийн хэрэгслийн хөрөнгө оруулалтын хувьд тогтмол хүүгийн орлоготой, эрсдэл багатай хөрөнгө оруулалт юм. Сангийн хөрвөх чадварыг хангах, багцын эрсдэлийн төвшинг бууруулах зорилгоор сангийн удирдаж буй хөрөнгийн 20%-д уг төрлийн хөрөнгө оруулалт хийнэ. Одоогоор Хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдаж буй засгийн газар болон нийслэлийн өрийн хэрэгсэл байхгүй байгаа бөгөөд зөвхөн компанийн өрийн хэрэгслүүд арилжигдаж байна. 2022 оны 6 сарын байдлаар хөрөнгийн бирж болон биржээс гадуурх зах дээр уг төрлийн бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас дунджаар 15%-ийн өгөөжтэй байна. Тэдгээр хэрэгслүүдээс дараах шалгуур үзүүлэлтүүдээр хөрөнгө оруулалт хийнэ. Үүнд:

- Мөнгөн урсгал. Өрийн хэрэгсэл гаргагч компанийн үйл ажиллагаа нь тогтвортой, ашигтай, нэмэх мөнгөн урсгалтай ажиллаж, эргэн төлөлтөө тогтвортой хийх чадвартай байх.

- Барьцаа хөрөнгө, тэдгээрийн хөрвөх чадвар. Өрийн хэрэгсэл гаргагч компанийн тухайн үнэт цаасанд барьцаа баталгаа болгон гаргаж буй хөрөнгийн хэлбэр, зах зээлийн үнэлгээ, дампуурах эрсдэл үүссэн тохиолдолд хөрвөх чадвар нь сайн байх.

- Хөшүүрэг. Бизнесийн онцлогоос хамааран тухайн компанийн хөшүүрэг их бага байж болох боловч салбарын дунджаас ихгүй байх. Өөрийн хөрөнгө ихтэйгээр үйл ажиллагаа явуулдаг байх нь хөрвөх чадварын баталгаа болдог.

3.2.5 Бэлэн мөнгө болон хадгаламжийн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулах стратеги

"Ашид Арвижих" хамтын хөрөнгө

оруулалтын сан нь нэгж эрхээ олон нийтэд худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг, гаргасан нэгж эрхээ буцаан худалдан авах үүрэг хүлээдэг нээлттэй хамтын хөрөнгө оруулалтын сан юм. Тиймээс сангийн нэгж эрхийг буцаан худалдан авах үүргийн дагуу сангийн нийт удирдаж буй хөрөнгийн 10%-ийг хөрвөх чадвар сайтай бэлэн мөнгө, банкны хадгаламжийн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийж, сангийн хөрвөх чадварыг хангаж, тогтмол мөнгөн урсгал бий болгож ажиллана. Ингэхдээ системийн нөлөө бүхий 5 том банканд хүү болон эрсдэлийг төвшинг харгалзан хөрөнгө оруулалт хийх стратеги баримтална.

3.2.6 Хөрөнгө оруулах хэрэгслүүдэд тавих хязгаарлалт

Хамтын хөрөнгө оруулалтын сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.11-26.13, 26.15, 26.18-д, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон "Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам"-ын 71.2-т заасан доорх хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээс өөр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно. Үүнд:

- Засгийн газрын өрийн хэрэгсэл;
- Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;
- Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;

• зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;

• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

• Санхүүгийн зохицуулах хорооноос болон нэгж эрх эзэмшигчдийн хурлаар зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслүүд.

Сангийн хөрөнгө оруулах хэрэгслээс гадна тэдгээрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон "Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох журам"-ын шаардлагад нийцүүлэн ажиллана.

Мөн Сангийн хөрөнгийг дээрх хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд оруулахдаа доорх хязгаарлалтын дагуу ажиллана. Үүнд:

о Хорооноос гаргасан Хамтын сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ХОС-н нийт активын 20 /хорь/ болон түүнээс дээш хувийг хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий арилжааны банкны хадгаламж, эсхүл харилцах дансанд байршуулахыг хориглоно; Ингэхдээ хэрэв тухайн банкны гаргасан үнэт цаасыг Сан эзэмшиж байгаа бол тэдгээрийн үнийн дүнг нэмж тооцно.

о Эдийн засгийн нэг салбарын хувьцаанд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нь нийт активын 25 /хорин тав/ хувиас хэтрэхгүй байна

о Сангийн нийт активын 10 /арав/ болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг 1 /нэг/ үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасанд оруулахыг хориглоно.

о Аливаа хуулийн этгээдийн нийт гаргасан үнэт цаасны 10 /арав/ болон түүнээс дээш хувийн үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх буюу нийт саналын эрхийн 10 /арав/ ба түүнээс дээш хувийг дангаар эзэмшихийг хориглоно.

о Сангийн менежер Сангийн нийт активын 5 /тав/ хувь хүртэлх хэмжээтэй хөрөнгө оруулалтыг бие даан шийдвэр гаргаж, хөрөнгө оруулах эрхтэй.

о Сангийн нийт активын 10 /арав/ хувиас дээш хөрөнгийг хөрвөх чадвар муу ангиллын хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно.

1.2.1 Хэрэв сангийн нийт активын 10 /арав/ хувиас дээш хувийг хөрвөх чадвар муутай хэрэгсэлд хөрөнгө оруулсан бол календарийн 30 /гуч/ хоногт багтаан хөрвөх чадварыг заасан төвшинд аваачих бөгөөд, дараагийн ТУЗ-н хуралд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тайлагнана.

1.2.2 Хөрөнгө оруулалтын сан нь санхүүгийн хөшүүрэг хэрэглэсэн, эсхүл үнэт цаасны үнийн бууралтаас ашиг хүртэх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын хэрэгслийг активын бүтцэдээ оруулахыг хориглоно.

3.2.7 Хөрөнгө оруулалтын судалгаа

Сангийн менежер, зах зээл судлаач, санхүүгийн шинжээч нарын баг нь хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээ хийхдээ top-down approach буюу дээрээс доош судалгааны арга ашиглан макро эдийн засгийн шинжилгээ, тухайн хувьцаат компанийн үйл ажиллагааг аявуулж буй салбар,

судалж шийдвэр гаргах болно.

- Компанийн шинжилгээ. Компанийн бизнес модель, хэрэглэгч, бүтээгдэхүүн, нөөц бололцоо, удирдлагын баг, хүний нөөц, санхүүгийн үзүүлэлтүүд гэх мэт олон хүчин зүйлүүд тухайн компанийн орлого, ашиг, боломж, чадавхыг тодорхойлж байдаг. Мөн хувьцаат компаниудын үнэлгээг хийхдээ онцлогоос нь хамааран P/E, P/B, EBITDA зэрэг multiplier ашиглах, Dividend Discount model, Gordon's Growth model, Хөрөнгөнд суурилсан үнэлгээний загвар зэрэг үнэлгээний аргуудыг хослуулан үнэлгээ хийж, бодит үнэлгээнээс хямдаар үнэлэгдэж буй компаниудад хөрөнгө оруулалт хийнэ.

- ### 3.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Зураг 14 Сангийн үйл ажиллагааны схем



түхай хуулийн 62 дугаар зүйлд заасан бөгөөд үүнээс гадна сангийн дүрэмд олгогдсон дараах бүрэн эрхийг эдэлнэ.

- Хөрөнгө оруулалтын менежментийн компанийг сонгох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах шийдвэр гаргах;

- Хөрөнгө итгэмжлэн хадгалах кастодиан банкыг сонгох, хөрөнгө хадгалах гэрээ байгуулах шийдвэр гаргах;

- Сангийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ын гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох

шийдвэр гаргах;

- Хөрөнгө оруулалтын менежментийн компани болон кастодиан банкны төлбөр, урамшууллын дээд хэмжээг тогтоох;

- Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон сангийн үйл ажиллагааны тухай журамд заасан бусад шийдвэр гаргах

Сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байх бөгөөд ээлжит хурал нь тайлант жилийн эхний 4 сарын дотор жилд нэг удаа хуралдах бол ээлжит бус хурлын сангийн дүрэмд зааснаас гадна дараах тохиолдолд хөрөнгө оруулалтын менежментийн компани зарлан хуралдуулна. Үүнд:

- Сангийн үйл ажиллагааны явцад цэвэр активын хэмжээ нь дараалан 10 хоногийн турш тухайн сарын үйл ажиллагаа эхэлсэн өдрийн хэмжээнээс 40% (дөчин хувь) буурсан;

- Хөрөнгө оруулалтын менежментийн компани татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсон эсхүл бусад шалтгааны улмаас хөрөнгө итгэмжлэн удирдах эрхийг өөр хөрөнгө оруулалтын менежментийн компанид шилжүүлэх шаардлага үүссэн;

- Кастодиан банк татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсон эсхүл бусад шалтгааны улмаас хөрөнгө итгэмжлэн хадгалах эрхийг өөр кастодиан банканд шилжүүлэх шаардлага үүссэн;

- Сан татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн;

- Хөрөнгө оруулалтын менежментийн компаниас Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг хийхийг шаардсан бусад нөхцөлд тус тус Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна.

3.3.3 Төлөөлөн удирдах зөвлөл

"Ашид Арвижих" хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон сангийн дүрмээр олгогдсон эрхийн хүрээнд сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгө оруулалтыг хамгаалах, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах, стратегийг тодорхойлох, сангийн үйл ажиллагааг хянах зэрэг үйл ажиллагааг явуулдаг, Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт

Сангийн эрх барих, хамтын удирдлага бүхий байгууллага юм.

Сангийн ТУЗ нь Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны тогтоосон журам, сангийн дүрэмд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

- Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал болон нэгж эрх эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

- Хөрөнгө оруулалтын менежментийн компанид олгох үйлчилгээний төлбөр, гүйцэтгэлийн урамшууллыг батлах;

- Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн аудитын байгууллагуудаас Сангийн аудитыг хийж, ажиллах аудитыг сонгож, түүнтэй гэрээ байгуулах нөхцлийг тогтоох, гэрээ байгуулах эрхийг гүйцэтгэх удирдлагад олгох;

- Сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, түүнийг сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах;

- Сангийн ашгаас нэгж эрх эзэмшигчдэд олгох ногдол ашгийн хэмжээ, түүнийг олгох журмыг тодорхойлох;

- Санг нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах талаар нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

- Томоохон хэмжээний хэлцлийг батлах шийдвэр гаргах;

- Сангийн дотоод хяналтын хорооны гишүүдийг томилох;

"Ашид Арвижих" хамтын хөрөнгө оруулалтын сангийн ТУЗ нь банк, даатгал, санхүү, хөрөнгө оруулалтын салбарт ажиллаж байсан өргөн туршлага, чадвартай 5 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 2 нь хараат бус гишүүн байна. Сангийн ТУЗ-ын гишүүд нь ямарваа нэгэн сонирхлын зөрчилгүй, хараат бусаар сангийн нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг нэгт тавин шийдвэр гаргах ба Сангаас аливаа хэлбэрийн цалин, урамшуулал авахгүй болно.

"Ашид Арвижих" хамтын хөрөнгө оруулалтын сангийн ТУЗ дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сангийн ТУЗ-ийн дарга Ш. Түмэнбаяр

Санхүүгийн зохицуулах хороо, Хөгжлийн банк, DBM ассет менежмент зэрэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад эдийн засаг, нийтийн бодлогын чиглэлээр хяналт шалгалт, зөвлөгөө өгөх төвшинд 15 жил ажилласан туршлагатай. Одоогоор “Дөрвөн улирлын ногоон байшин” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэдэг. 2006 онд Орос улсын MGIMO их сургуульд эдийн засгийн бакалавр мэргэжлээр суралцаж төгссөн бөгөөд Японы Хитоцубаши Их сургуульд мэргэжил дээшлүүлж нийтийн бодлого чиглэлээр магистр хамгаалсан.

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сангийн ТУЗ-ийн гишүүн А. Батпүрэв

Монгол Улсын Гадаад харилцааны яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, Юнител групп, Скайтел групп зэрэг төр, хувийн хэвшлийн байгууллагуудад 20 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр эдийн засагчийн хувьд санхүүгийн салбарын хөгжил, нийтийн санхүү ба орлогын менежментийн сэдвээр судалгаа хийдэг бол бизнесийн зөвлөхийн хувьд стратеги удирдлага, маркетингийн чиглэлээр мэргэшсэн. 2004 онд Санхүү, Эдийн Засгийн Дээд Сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр (BBA), 2013 онд Сидней Их Сургуулийг Санхүүгийн эдийн засгийн магистр (Ms.Econ) зэрэгтэй төгссөн, 2019 оноос БНХАУ-ын Эдийн Засаг, Бизнесийн Их Сургуульд Бизнесийн эдийн засгийн докторантаар (PhD candidate) суралцаж буй. А.Батпүрэв нь Ашид Ассет Менежмент ҮЦК, Инфорум Консалтинг, ШИМТ Боловсрол компаниудын үүсгэн байгуулагч партнер, Монголын Хөрөнгийн Бирж ХК-ын Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн, Санхүүгийн Хүртээмж-Хөгжил Санаачилга ТББ-ын үүсгэн байгуулагч гишүүн.

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сангийн ТУЗ-ийн гишүүн Б. Энхбаяр

Бизнесийн удирдлага, эдийн засгийн чиглэлээр 20 гаруй жил Бодь даатгал, Петровис, Голомт Банк, Европын Сэргээн Босголтын Банкны Монгол дахь салбар,

Юнител Корпораци зэрэг төмөрхон компаниудад удирдах болох зөвлөхийн төвшинд ажиллаж байсан. Ажиллах хугацаандаа Голомт банкны Master card, VISA картыг Монголд нэвтрүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлсэн, Unitel группийн брендийг хариуцаж ажиллаж байсан зэрэг туршлагатай. Санхүү эдийн засгийн их сургуулийг 2003 онд Бизнесийн удирдлага, эдийн засаг чиглэлээр төгссөн бөгөөд Удирдлагын академийг удирдахуйн ухааны магистр, хамгийн сүүлд 2021 онд Шихихутуг хууль зүйн их сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн.

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сангийн ТУЗ-ийн хараат бус гишүүн З. Ганболд

“Оюу Толгой” ХХК-д 2009 оноос хойш одоог хүртэл Системийн мэргэжилтнээр ажилладаг. Монгол улсын их сургуулийг 2003 онд төгссөн бөгөөд програм хангамжийн инженерийн бакалавр зэрэгтэй. Компанийн засаглалын гэрчилгээтэй хуульд заасан тохиромжтой этгээд юм.

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сангийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Э. Эрдэнэцэцэг

2007 оноос хойш банк, санхүүгийн салбарт хөрөнгө оруулалт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн чиглэлээр 15 гаруй жил ажилласан туршлагатай, санхүүгийн зах зээлийн бодлого, журмын талаар өндөр мэдлэгтэй санхүүгийн мэргэжилтэн юм. Тэрээр 2007 онд Английн Миддлсекс-ын Их сургуульд Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн чиглэлээр бакалавр, 2014 онд Австралийн Централ Күүинсландын Их сургуульд Санхүүгийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн. Үүний зэрэгцээ тэрээр БОНЗ, ногоон болон уур амьсгалын санхүүжилт, ЖМТ, нийгмийн инновацийн чиглэлээр ажиллаж карьераа дээшлүүлсэн.

3.3.4 Гүйцэтгэх удирдлага

“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК (ХОМК) нь Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон ТЗ-309/035 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий мэргэжлийн хөрөнгийн удирдлагын компани бөгөөд Санг

үүсгэн байгуулж, Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд үндэслэн Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах, Сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн дагуу хөрөнгө оруулах шийдвэрийг бие даан гаргах, Сангийн хөрөнгийг удирдан, зохион байгуулах зэрэг гүйцэтгэх удирдлагын үүргийг хэрэгжүүлнэ. ХОМК нь сангийн менежерийг томилон, түүгээр дамжуулан дээрх эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Сангийн Хөрөнгө оруулалтын зөвлөх нь сангийн гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

ХОМК нь Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу дараах үйлчилгээг санд үзүүлнэ.

Үүнд:

- Сангийн нэгж эрхийг бусдад худалдах, олон нийтээс Санд хөрөнгө татан төвлөрүүлэх;

- Санд төвлөрүүлсэн хөрөнгийг хууль тогтоомж, сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогод заасан хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулах, хөрөнгө оруулалт хийх;

- Сангийн нэгж эрх эзэмшигчдийн тухайлсан бүртгэлийг кастодианаар хийлгэх, түүнд үндэслэн нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл хийх;

- Нэгж эрх эзэмшигчдийн хурал болон Сангийн ТУЗ-ын хурлын зохион байгуулах;

- Сангийн нэгж эрх эзэмшигчдийг болон Хороонд хууль тогтоомж, Хорооны журам, сангийн дүрэм, журамд заасан мэдээллийг хүргэх, мэдээллээр хангах;

- Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах;

- Санг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, сангийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх;

- Санг төлөөлөх сангийн менежерийг томилох;

- Сангийн хөрөнгийг захиран зарцуулах хэлцлийн итгэмжлэн удирдаж буйгаамэдэгдсэний үндсэндээр хэрэгжүүлэх;

- Санг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх болон арбитрын процесст оролцох;

- Сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангуудыг хууль тогтоомж, сангийн журамд заасан хугацаанд гаргах,

тайлагнах;

- Сангийн нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хийх;

- Сангийн үйл ажиллагаанд шаардлагатай аудит, үнэлгээ, хуулийн зөвлөх үйлчилгээ, кастодиан зэрэг хуулийн этгээдтэй холбогдох гэрээг байгуулах, түс гэрээний хэрэгжилтийн хангуулах;

- Сангийн нэгж эрхийг эрэлт, сангийн бодлогод тулгуурлан гаргах, сангийн дүрэм, журамд заасан ёсоор худалдан авах ажиллагааг зохион байгуулах;

- Сангийн орлогоос ТУЗ-н шийдвэрт заасан ногдол ашиг хувиарлах, түүнийг шилжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах;

- Сангийн үйл ажиллагааг зогсоож, татан буулгах, өр төлбөрийг барагдуулах, нэгж эрх эзэмшигчдэд орлого хувиарлах ажлыг зохион байгуулах;

ХОМК нь Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах бүрэн эрх бүхий Сангийн менежерийг томилох;

- Санг холбогдох хууль тогтоомж, Сангийн дүрэм, Сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, Сангаас баталсан холбогдох журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг шаардах;

- Сангийн зардлыг бодитоор тогтоох, ХОМК-ийн үйлчилгээний төлбөр болон урамшууллыг заасан хугацаанд олгохыг шаардах;

- Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх;

ХОМК нь Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Холбогдох хууль тогтоомж, Сангийн дүрэм, журамд нийцсэн хөрөнгө хадгалах гэрээний үндсэн дээр кастодианыг сонгож, Сангийн хөрөнгийг хадгалуулах;

- Сангийн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой санхүүгийн анхан шатны бүх баримтыг үйлдсэн болон хүлээн авсан даруйдаа хувийг нь мэргэшсэн нягтлан бодогч болон кастодиандаа хүргүүлэх;

- Хорооноос тогтоосон мэдээ, тайланг тогтоосон хэлбэрээр, хугацаанд нь гаргаж өгөх;

- Сангийн нийтэд болон сангийн нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэл өгөх журмын дагуу холбогдох мэдээллийг нийтэд болон Сангийн нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэх;

- Хорооны зөвшөөрөлгүйгээр өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн болон эрх бүхий албан тушаалтан, төлөөлөгчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй байх;

- Хорооноос хүлээн зөвшөөрсөн аудитын компанитай аудитын дүгнэлт гаргуулах гэрээ байгуулах;

- Нэгж эрх эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүнд нийцүүлэн энэхүү журмаар хүлээсэн үүргээ биелүүлэх болон хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх;

- Сангийн хөрөнгийн багцтай холбоотой санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хорооноос тогтоосон журамд нийцүүлэн өөрийн хөрөнгийн бүртгэлээс тусад нь хөтлөх;

- Нэгж эрх эзэмшигчдэд Сангийн дүрэм болон хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн дагуу шаардлагатай тайлан, мэдээллийг тогтсон хугацаанд гаргаж мэдээлэх;

- Нэгж эрх эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;

- Сангийн Төлөөлөн удирдах зөвлөл өөрөөр шийдвэрлээгүй бол дараагийн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай гэрээ байгуулах хүртэл ХОМК нь энэхүү журам болон Сантай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр хүлээсэн үүргээ үргэлжлүүлэн биелүүлэх;

- Энэхүү журамд Сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн хүрлын шийдвэрээр өөрчлөлт орсон бол өөрчлөлтийг ажлын 5 /тав/ өдрийн дотор Хороо болон Нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэх;

- Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 46.1 болон Хорооноос баталсан "Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам"-ын 7-р зүйлд заасан хориглосон үйл ажиллагааг явуулахгүй байх, мөн явуулахад чиглэсэн аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийхгүй байх;

- Холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг;

Хөрөнгө оруулалтын зөвлөх Б.Батгариг

Б.Батгариг нь Эдийн засагч, Санхүүч мэргэжилтэй, ОУ-ын Санхүүчдийн CFA нийгэмлэгийн CFA level III candidate. "Ашид Ассет Менежмент УЦК" ХХК-ийн Сангийн менежер, санхүүгийн шинжээч бөгөөд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Бизнесийн байгууллагуудад болон Европын сэргээн босголт, хөгжлийн банкны /ЕСБХБ/ төсөл дээр санхүүгийн менежерээр ажиллаж байсан туршлагатай. Санхүүгийн шинжээчийн хувьд хөрөнгө оруулалтын багцын удирдлага, эрсдэлийн менежмент болон компанийн үнэлгээний чиглэлээр мэргэшсэн. МҮЦАЭХ-ноос олгодог хөрөнгийн зах зээлд мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхтэй, Санхүүгийн Зохицуулах Хорооны "зохистой этгээд"-ийн шаардлагыг бүрэн хангасан.

3.3.5 Сангийн дотоод хяналтын мэргэжилтэн

Сангийн дотоод хяналтын мэргэжилтэн нь сангийн ТУЗ-аас томилогдож, сангийн үйл ажиллагаанд болон сангийн менежерийн үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх, кастодиан банкны үйл ажиллагааг хянах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг, эдгээр үйл ажиллагааг сангийн ТУЗ-д тайлагнадаг хяналтын эрх, үүрэг бүхий бие даасан мэргэжилтэн юм.

ДХХ-ийн гишүүн Б.Бадамсүрэн

Б.Бадамсүрэн нь Санхүү Эдийн Засгийн Их сургуулийг 2021 онд санхүү менежментийн мэргэжлээр төгссөн. 2021 онд "Монголын Үнэт Цаас Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ-өөс Монгол Улсын үнэт цаасны зах зээлд Хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх авсан болно. Мөн тус онд Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Даатгалын Зуучлагчдын Холбооноос хамтран зохион байгуулсан "Даатгалын зуучлагчийн эрх олгох сургалт"-ын гэрчилгээ авсан болно. 2021 оноос "Нэйшнл Иншуранс Брокерэйж Сервисэс" ХХК-ийн даатгалын мэргэжилтнээр ажиллаж байгаад өнөөдрийн байдлаар "Ашид Ассет Менежмент УЦК" ХХК-д дотоод ажилтнаар ажиллаж байна.

Сангийн дотоод хяналтын мэргэжилтэн нь дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Сангийн дүрэм,

Сангийн хяналтын үйл ажиллагааны журам болон Сангийн дотоод хяналтын журмыг мөрдлөг болгон ажиллана.

3.4 САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ ЖУРАМ

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”, “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, “Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”, “Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн мэргэжлийн үйл ажиллагааны болон ажилтны ёс зүйн дүрэм”, “Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох журам”, “Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогчийг бүртгэх тухай журам”-уудын дагуу болон дараах багц журмын дагуу үйл ажиллагаагаа явуулах болно. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах журам;
- Хөрөнгө оруулалтын сангийн эрсдэлийн удирдлагын журам;
- Хөрөнгө оруулалтын сангийн хяналтын үйл ажиллагааны журам;
- Хөрөнгө оруулалтын сангийн татан буулгах үйл ажиллагааны журам;
- Хөрөнгө оруулалтын сангийн дотоод хяналтын журам;
- Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдан авах, буцаан худалдах захиалга өгөх журам;
- Хөрөнгө оруулалтын сангийн орлогыг сангийн активд бүртгэх журам;
- Хөрөнгө оруулалтын санд буцаан худалдсан нэгж эрхийн үнийг төлөх хугацаа, журам;
- Хөрөнгө оруулалтын сангийн цэвэр активд суурилсан нэгж эрхийн үнэ буюу нэгж эрхийг худалдах, худалдан авах үнийг тодорхойлох журам;
- Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчийг бүртгэх хугацаа, журам;

• Хөрөнгө оруулалтын сангийн зардлын зүйл, дээд хэмжээг тогтоох журам;

• Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нийтэд болон сангийн гишүүдэд мэдээлэл өгөх журам, мэдээлэх мэдээллийн төрөл, мэдээллийг түгээх хэлбэр;

• Хөрөнгө оруулалтын сангийн орлогоос гишүүдэд орлого хуваарилах нөхцөл, журам;

• Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, НББ хөтлөх, цэвэр активын үнэлгээ хийх журам;

Мөн бид аливаа хэлбэрийн сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд сонирхлын зөрчил байгаа эсэхийг тогтоож, зайлсхийж, нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэх, хөндөгдөхгүй байх бодлого барьж ажиллана. Мөн “Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан нь өөрсдийн үйл ажиллагаандаа Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон ОУ-ын СГА нийгэмлэг, Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны мэргэжилтний ёс зүйн дүрмийг сангийн нууцын тухай болон үйл ажиллагааны журамд тусгаж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, сангийн нэгж эрх эзэмшигчдийн мэдээллийн аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалж ажиллана.

3.5 САНГИЙН ХӨРӨНГӨ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ


“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан нь 500'000'000 /таван зуун сая/ ширхэг зарласан нэгж эрхтэй байх бөгөөд Сан нь үүсгэн байгуулах бичиг баримт, уг нэгж эрхийн танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлснээс хойш 3 сарын хугацаанд олон нийтэд танилцуулж, 1 сарын хугацаанд, 10'000'000 /арван сая/ ширхэг нэгж эрх нэг бүрийг 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнээр анхдагч зах зээлийн арилжаанд гаргаж 1'000'000'000 /нэг тэрбум/ төгрөг татан төвлөрүүлсний дараа үйл ажиллагаагаа эхлүүлэх тусгай зөвшөөрөл авна.

Сан нь хамтын нээлттэй сан учир нэгж эрхээ бусдад худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр зарласан нэгж эрхээс олон нийтэд худалдах бөгөөд 2022 оны эцэст сангийн нийт удирдаж буй

татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 10.0 / арав/ тэрбум төгрөг, Сангийн үйл ажиллагаа явуулах хугацааны эцэст нийт удирдаж буй хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 42.7 / дөчин хоёр аравны долоо/ тэрбум төгрөг байхаар төлөвлөж байна. Сан өөрийн нэгж эрхийг олон нийтэд худалдах, буцаан худалдан авах ажиллагааг өөрсдийн онлайн платформ болон гар утасны аппликэйшн дээр явуулах болно.

Бид өөрсдийн зорилтот хөрөнгө оруулагчдын зан төлөв, санхүүгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын чадамжийг тодорхойлох судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн хөрөнгө оруулагчдын сангийн нэгж эрхээ буцаан худалдах таамгийг гаргасан болно.

Бид Улаанбаатар хот болон орон нутгийн 11 аймгуудаас 15-60 насны 1688 хүнээс тухайн хүний хувийн зан төлөв, санхүүгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын чадамжыг тодорхойлох асуумж судалгаа авсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 38.4% нь ирээдүйн учирч болзошгүй санхүүгийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хадгаламж үүсгэсэн байсан. Нийт хадгаламжтай хүмүүсийн 64% нь өөрсдийн санхүүгийн байдлыг тогтвортой гэж үнэлсэн бөгөөд сар бүр нэмж хуримтлал үүсгэдэг хүмүүс байв. Мөн нийт хадгаламжтай хүмүүсийн 30% нь богино хугацаанд буюу 1-5 жилд үүссэн санхүүгийн асуудлаа хадгаламжаараа шийдвэрлэх буюу хадгаламжаасаа мөнгөө татах төлөвтэй байгаа бол нийт хадгаламжтай хүмүүсийн 51% нь 5 жил болон түүнээс урт хугацаанд хадгаламжаасаа мөнгө татах төлөвтэй байлаа. Тиймээс бид манай нийт хөрөнгө оруулагчдын 30 /гуч/ хувь нь ойрын 5 жил дотроо мөнгөө эргүүлэн татах магадлалтай /redemption pattern/, 50 /тавь/ хувь нь 5 жил болон түүнээс урт хугацаанд хөрөнгө оруулалтаа эргүүлэн татах магадлалтай гэж авч үзсэн.



Хүснэгт 6 Сангийн нэгж эрх гаргах болон буцаан худалдан авах төлөвлөгөө /сая төгрөг/



		2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031
Эхний үлдэгдэл		1,000	10,000	15,100	19,300	23,500	27,700	30,700	33,700	36,700	39,700
Шинээр гаргах нэгж эрх	1 сард	1,500	500	500	500	500	500	500	500	500	500
	1 жилд	9,000	6,000	6,000	6,000	6,000	6,000	6,000	6,000	6,000	6,000
Буцаан авах нэгж эрх	1 сард	-	150	150	150	150	250	250	250	250	250
	1 жилд	-	900	1,800	1,800	1,800	3,000	3,000	3,000	3,000	3,000
Нэгж эрхийн өөрчлөлт	1 сард	1,500	350	350	350	350	250	250	250	250	250
	1 жилд	9,000	5,100	4,200	4,200	4,200	3,000	3,000	3,000	3,000	3,000
Эцсийн үлдэгдэл		10,000	15,100	19,300	23,500	27,700	30,700	33,700	36,700	39,700	42,700

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан нь 2023 оноос сар бүр тогтмол 0.3-1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийдэг 500-1700 хөрөнгө оруулагчтай болж сар бүр 500 сая төгрөг шинээр татан төвлөрүүлж ажиллана. Буцаан худалдаж авах нэгж эрхийн дүнг эхний 5 жилд шинээр гаргаж буй нэгж эрхийн 30%, дараагийн 5 жилд шинээр гаргах нэгж эрхийн 50% байна гэж үзсэн. 2031 онд сангийн удирдаж буй хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 42.7 тэрбум байхаар төлөвлөж байна.

3.6 САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /BS, IS, CS/

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан 1 тэрбум төгрөг татан төвлөрүүлснээр үйл ажиллагаагаа эхлэх

бөгөөд 2022 оны 7 сараас эхлэн сар бүр 1.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлж, жилийн эцэст сангийн нийт удирдаж буй татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 10.0 тэрбум төгрөг байна гэж төлөвлөж байна. 2023 оноос сар бүр 500 сая төгрөг татан төвлөрүүлж ажиллана. Сан хөрөнгө оруулалт хийхдээ өөрсдийн модель багцын дагуу хөрөнгийн 70%-ийг нээлттэй ХК-ийн хувьцаа, 20%-ийг засгийн газар, компанийн өрийн хэрэгсэл, 10%-ийг банкны хадгаламж болон харилцах дансанд тус тусын стратегийн дагуу хөрөнгө оруулалт хийнэ.

Сангийн санхүү байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, мөнгөн урсгалын тайлан зэргийг сангийн ажиллах хугацаанд буюу 10 жилийн хугацаатайгаар 2031 оныг дуустал үйл ажиллагаа явуулахаар төсөөлж гүйцэтгэлээ.

Хүснэгт 7 Сангийн санхүү байдлын тайлангийн төсөөлөл /сая төгрөг/

Санхүү байдлын тайлан	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031
Хөрөнгө										
Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,016	1,706	2,403	3,230	4,144	5,164	6,264	7,574	9,081	10,563
Бэлэн мөнгө	203.8	339.5	480.8	649.8	813.8	1,046.3	1,255	1,539	1,843	1,937
Банкны хадгаламж	812.5	1,367	1,922	2,580	3,331	4,117	5,009	6,035	7,238	8,626
Хөрөнгө оруулалт	9,113	15,328	21,631	28,995	37,516	46,186	56,305	68,006	81,558	98,302
Хувьцаа	7,088	11,923	16,826	22,565	29,166	35,936	43,805	52,906	63,458	80,202
Өрийн хэрэгсэл	2,025	3,405	4,805	6,430	8,350	10,250	12,500	15,100	18,100	18,100
Нийт хөрөнгө	10,129	17,035	24,034	32,225	41,660	51,350	62,569	75,580	90,639	108,865
Хойшлогдсон татварын өглөг	8.6	162.3	403.1	750.5	1,206	1,789	2,507	3,382	4,436	5,844
Нийт өр төлбөр	8.6	162.3	403.1	750.5	1,206	1,789	2,507	3,382	4,436	5,844
Хувь нийлүүлсэн хөрөнгө	10,000	15,100	19,300	23,500	27,700	30,700	33,700	36,700	39,700	42,700
Хуримтлагдсан ашиг	120.2	1,772	4,331	7,974	12,755	18,861	26,362	35,498	46,502	60,321
Нийт эздийн өмч	10,120	16,872	23,631	31,474	40,455	49,561	60,062	72,198	86,202	103,021
Нийт өр төлбөр ба эздийн өмч	10,129	17,035	24,034	32,225	41,660	51,350	62,569	75,580	90,639	108,865

Сан нь Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан "Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох журам" болон энэхүү хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан модель багцын дагуу сар бүр хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн сангийн нийт хөрөнгөд эзлэж буй хэмжээг гаргаж, тэдгээрийн зохистой харьцааг шалгаж, тохируулга хийн ажиллах болно.

2022 оны хувьд 6 сараас эхлэн хагас жил ажиллах бөгөөд жилийн эцэст сангийн нийт активын үнэлгээ нь 10.1 тэрбум төгрөг байх бол 10 жилийн дараа буюу 2031 онд сангийн нийт активын үнэлгээ 108.9 тэрбум болж өсөх төлөвтэй байна. Сангийн нийт активын үнэлгээ нь сангийн хувь нийлүүлсэн хөрөнгөөс 2.5 дахин өсөж 108.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байх төлөвтэй байна.

Хүснэгт 8 Орлого үр дүнгийн тайлангийн төсөөлөл /сая төгрөг/

Орлого үр дүнгийн тайлан	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031
Орлого										
Бондын хүүгийн орлого	15 0	349	542	904	1,100	1,380	1,682	2,042	2,430	2,884
Харилцахын хүүгийн орлого	141	10 19	15 11	20 76	27 52	33 64	42 94	51 31	62 64	74 80
Хадгаламжийн хүүгийн орлого	12 5	96 4	144	197	259	327	401	486	584	698
Хувьцаа борлуулсны ашиг	33 6	192	275	357	475	589	712	864	1,035	503
Хувьцааны бодит үнэ цэнийн өсөлтийн олз, гарз	363 9	2,084	3,137	4,322	5,686	7,182	8,807	10,687	12,867	16,191
Нийт орлого	426 5	2,731	4,114	5,801	7,548	9,511	11,645	4,130	16,978	20,351
Зардал										
ХОМК-ын үйлчилгээний зардал	115 0	404	572	769	995	1,225	1,494	1,804	2,163	2,518
ХОМК-ын өсөлтийн бонус	11 1	249	383	565	733	916	1,128	1,369	1,644	1,401
Кастодиан үйлчилгээний зардал	41 8	147	208	280	362	446	543	656	787	916
IT үйлчилгээний зардал	25 0	40	53	55	58	61	64	67	70	74
Аудит үйлчилгээний зардал	-	40	42	44	46	49	51	54	56	59
Бусад зардал	100 0	15	15	40	42	30	30	30	30	30
Нийт зардал	293	895	1,272	1,752	2,236	2,726	3,310	3,979	4,751	4,997
Татварын өмнөх ашиг	134	1,836	2,843	4,048	5,312	6,784	8,335	10,151	12,227	15,354
Татварын зардал	4 8	29 8	43 5	57 5	76 2	94 9	115 6	140	168	127 6
Татварын дараах ашиг	120 2	1,652	2,559	3,644	4,780	6,106	7,502	9,136	11,004	13,819
Хойшлогдсон татвар	8 6	154	241	347	455	584	718	875	1,055	1,408

Сангийн үйл ажиллагааны орлого нь сангийн хөрөнгө оруулсан өрийн хэрэгсэл буюу бондын хүүгийн орлого, хадгаламж, харилцах дансанд байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого, эзэмшиж буй хувьцааны ногдол ашиг, борлуулсан хувьцааны үнийн өсөлтөөс үүссэн ашигаас бүрдэнэ. Харин хөрөнгө оруулсан хэрэгслүүдийн үнэ цэнийн өсөлтөөс үүссэн, мөнгөжүүлээгүй хөрөнгө оруулалтын өгөөж нь сангийн нийт хөрөнгийн цэвэр үнэ цэнийг нэмэгдүүлэх боловч ногдол ашиг хуваарилах орлогод тооцогдохгүй.

Сангийн зардал нь хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний буюу ХОМК-ынажлын төлбөр, хөрөнгө хадгалах үйлчилгээ буюу кастодианы зардал, сангийн ашиг зорилтот өгөөжөөс давсан тохиолдолд менежментийн компанид олгох бонус болон мэдээллийн технологи, хууль, аудит зэрэг мэргэжлийн үйлчилгээний бусад зардлуудаас бүрдэнэ.

ХОМК-ын үйлчилгээний зардлын хувьд тухайн жилд удирдаж буй хөрөнгийн 2.2% байна. ХОМК-ын өсөлтийн бонус нь сангийн удирдаж буй хөрөнгө сангийн зорилтот өгөөж буюу 15%-ийн өсөлтөөс илүү гарсан мөнгөн дүнгийн /net growth over hurdle rate/ 20% байна.

Жишээлбэл: Сангийн татан төвлөрүүлсэн хөрөнгө 2022 оны эцэст 10 тэрбум төгрөг, үүн дээр 2023 оны туршид татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 5.1 тэрбум төгрөг, 2023 оны эцэст нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 15.1 тэрбум төгрөг байх үед зорилтот өгөөжийн дагуу 2023 оны эцэст Сангийн нийт хөрөнгө 16.9 тэрбум төгрөг болж өссөн байх ёстой атал бодит гүйцэтгэлээр Сангийн нийт хөрөнгө 17.9 тэрбум төгрөг болж өссөн тул зорилтот өгөөжийн /15%/ тооцооллоос илүү гарсан өсөлт болох 1.0 тэрбум төгрөгөөс 20%-ийн

урамшуулал болох 203 сая төгрөг ХОМК-ийн бонус болж олгогдох болно.

Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний зардал болон кастодианы зардал нь 2.2% болон 0.8% буюу нийт 3.0% байхаар тооцоолол хийсэн болно. Сангийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад зайлшгүй шаардлагатай IT үйлчилгээний зардал болон Аудитын үйлчилгээний зардал нь Сангийн удирдаж буй хөрөнгийн 0.4% болно.

Хамтын нээлттэй сан нь нэгж эрхээ байнга олон нийтэд санал болгож, эрэлтийн хэмжээгээр худалдаж хөрөнгө босгодог

тул хөрөнгө босгох, нэгж эрхээ олон нийтэд танилцуулах зэрэг зардлууд жил бүр бага хэмжээгээр гарахаар төлөвлөж байна. Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтыг сангийн үйл ажиллагааны хугацааны эцэст худалдахаар төлөвлөсөн бөгөөд хувьцааны хөрөнгө оруулалтаас хэрэгжээгүй олз үүссэнийг хойшлогдсон татварын данс үүсгэж бүртгэсэн.

Мөнгө санг байгуулах, хэрэглэгчийн болон сангийн удирдлагын систем хөгжүүлэхтэй холбоотой зардлыг 100% ХОМК-ийн зүгээс санхүүжүүлж байгаа бөгөөд сангийн тооцоололд тусгагдаагүй болно.

Хүснэгт 9 Мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл /сая төгрөг/

Мөнгөн урсгалын тайлан	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал										
Үйл ажиллагааны орлого	-	-	-	-	-	-	-	-	-	-
Үйл ажиллагааны зардал	(298)	(925)	(1,315)	(1,810)	(2,312)	(2,821)	(3,426)	(4,119)	(4,919)	(5,125)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал	(298)	(925)	(1,315)	(1,810)	(2,312)	(2,821)	(3,426)	(4,119)	(4,919)	(5,125)
Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал										
Хувьцаа борлуулсны мөнгө	310	1,010	1,450	1,880	2,500	3,100	3,750	4,550	5,450	2,650
Бондын хүүгийн орлого	15	349	542	904	1,100	1,380	1,682	2,042	2,430	2,884
Харилцах хүүгийн орлого	14	102	151	208	275	336	429	513	626	748
Багц бүрдүүлэлт	(9,825)	(5,408)	(4,751)	(5,026)	(5,351)	(4,460)	(4,840)	(5,240)	(5,720)	(3,390)
Хувьцаа	(7,000)	(3,570)	(2,940)	(2,940)	(2,940)	(2,100)	(2,100)	(2,100)	(2,100)	(2,700)
Бонд	(2,025)	(1,380)	(1,400)	(1,625)	(1,920)	(1,900)	(2,250)	(2,600)	(3,000)	-
Хадгаламж	(800)	(458)	(411)	(461)	(491)	(460)	(490)	(540)	(620)	(690)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал	(9,499)	(4,039)	(2,744)	(2,221)	(1,724)	54	635	1,403	2,223	2,219
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал										
Анхны нэгж эрх борлуулсны орлого	1,000	-	-	-	-	-	-	-	-	-
Нэгж эрх нэмж борлуулсны орлого	9,000	6,000	6,000	6,000	6,000	6,000	6,000	6,000	6,000	6,000
Нэгж эрх буцаан худалдаж авсны зардал	-	(900)	(1,800)	(1,800)	(1,800)	(3,000)	(3,000)	(3,000)	(3,000)	(3,000)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал	10,000	5,100	4,200	4,200	4,200	3,000	3,000	3,000	3,000	3,000
	-	-	-	-	-	-	-	-	-	-
Цэвэр мөнгөн урсгал	204	136	141	169	164	232	209	283	304	94
Жилийн эхний бэлэн мөнгө	-	204	339	481	650	814	1,046	1,255	1,539	1,843
Жилийн эцсийн бэлэн мөнгө	204	339	481	650	814	1,046	1,255	1,539	1,843	1,937

3.7 САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

Сан нь Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох журам” болон сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан модель багцын дагуу сар бүр

хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн сангийн нийт хөрөнгөд эзлэж буй хэмжээг гаргаж, эзэмшиж буй хувьцаанаас тодорхой хэмжээг зарж, бэлэн мөнгө, хадгаламж, өрийн хэрэгсэлрүү хөрөнгө оруулалт нэмж хийж, зохистой харьцааг барьж ажиллана.

Хүснэгт 10 Сангийн хөрөнгийн зохистой харьцаа

Хөрөнгө оруулалтын хэрэгсэл	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031
Харилцах хадгаламж	10 0%	10 0%	10 0%	0 0%	10 0%	10 0%	10 0%	10 0%	10 0%	10 0%
Хувьцаа	70 0%	70 0%	70 0%	70 0%	70 0%	70 0%	70 0%	70 0%	70 0%	73 0%
Өрийн хэрэгсэл	20 1%	20 0%	20 0%	20 0%	20 0%	20 0%	20 0%	20 0%	20 0%	17 0%
Нийт	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%

3.8 САНГИЙН ЗАРДАЛ

Сангийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай зардлуудад дараах зардлууд хамаарна. Үүнд:

- Хөрөнгө босгох, нэгж эрх олон нийтэд танилцуулахтай холбоотой зардал

- Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний хөлс, гүйцэтгэлийн урамшуулал

- Хөрөнгө хадгалах кастодиан үйлчилгээний төлбөр, шимтгэл

- Хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтаа зарахтай холбоотой брокерийн үйлчилгээний хөлс

- Татварын зардал

- IT үйлчилгээний зардал

- Аудитын зардал

- Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбоотой зардал

- Санг үүсгэн байгуулах зардал

- Сангийн хэрэглэгчийн болон удирдлагын систем хөгжүүлэх зардал

- Сангийн нэгж эрх эзэмшигчдэд тайлан, мэдээлэл хүргүүлэхтэй холбоотой зардал

Сангийн хэрэглэгчийн болон удирдлагын систем хөгжүүлэхтэй холбоотой зардлуудыг ХОМК-ийн зүгээс санхүүжүүлж байгаа бөгөөд сангийн тооцоололд тусгагдаагүй болно.

Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний зардал болон кастодианы зардал нь 2.2% болон 0.8% буюу нийлбэр дүнгээр сангийн тухайн жилийн активын дундаж дүнгээс 3.0%-иас хэтрэхгүй байхаар төсөөлөл хийсэн болно.

Сангийн нийт зардал нь сангийн тухайн жилийн активын дундаж дүнгийн 5.0%-иас хэтрэхгүй байна. Тухайн тайлант хугацааны хувьд сангийн үйл ажиллагаанд зайлшгүй гэж үзсэн нэмэлт зардлуудыг нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэж болно.

3.9 САНГИЙН ТАТВАР

“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан нь Монгол улсын Татварын ерөнхий хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон татварын бусад холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ажиллана.

Ингэхдээ сангийн орлогын хувьд орлогын хэлбэрээс хамаарч Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу орлогын хэлбэрээс хамаарч 5-10%, нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахдаа Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу 5%, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 10%-ийн албан татварыг, Монгол улсад байрладаггүй албан татвар төлөгчийн хувьд ногдол ашгийн орлогод 20%-ийн албан татвар тус тус суутгаж ажиллана.

3.10 САНГИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Сангийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, сангийн дүрэм болон

бусад холбогдох журмын дагуу Сангийн ТУЗ гаргах болно. Сангийн хувьд үйл ажиллагаа явуулах хугацаандаа жил бүрийн цэвэр ашгийн тодорхой хувийг Сангийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилж болох бөгөөд уг шийдвэрийг Сангийн ТУЗ гаргана.

Сангийн ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэх ба ингэхдээ ногдол ашгийг Сангийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна. ТУЗ нь дор дурдсан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа тохиолдолд Нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилна. Үүнд:

- Ногдол ашиг төлөх нь Сангийн хөрвөх чадвар, эрсдэлийн менежментийн зохистой хэмжээнд нөлөөлөхгүй байх
- Ногдол ашиг төлсөний дараа Сан нь төлбөрийн чадвартай байх
- Ногдол ашиг төлсөний дараа Сангийн удирдаж буй хөрөнгийн хэмжээ нь өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгө, түүнийг татан буулгах зардал зэргийн нийлбэрээс илүү байх
- Сан холбогдох бүх зардал, татварыг төлсөний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна
- Ногдол ашиг төлсөний дараа Сан нь холбогдох хууль, журмаар заасан шалгуур үзүүлэлт, харьцаануудыг хангаж байх

Сан нь ногдол ашиг хуваарилахдаа холбогдох зардал, өр төлбөрийг бүрэн төлж гүйцэтгэсний дараа, хуулийн хүрээнд ногдох албан татварын дагуу суутгасан дүнг хуваарилна. Ногдол ашиг хуваарилахдаа нэгж эрх эзэмшигчдэд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг олон нийтэд мэдээллэж, ногдол ашиг хуваарилсан тайланг холбогдох хууль, журмын дагуу мэдээллэнэ.

3.11 ТАТАН БУУГДАХ ТОХИОЛДОЛД ОРЛОГО ХУВААРИЛАХ БОДЛОГО

"Ашид Арвижих" хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа дуусгавар болох эсхүл сан татан буугдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн

38 дугаар зүйлд заасны дагуу татан буугдсан сангийн хөрөнгийг сангийн нэгж эрх эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн дагуу хувь тэнцүүлэн олгоно. Ингэхдээ сангийн хөрөнгийг хуваарилахаас өмнө дараах дарааллын дагуу өр төлбөрийг барагдуулсан байна. Үүнд:

- Тухайн сангийн төлөх татварын өр, төлбөр;
 - Хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлсэн хөрөнгө оруулалтын менежментийн компани болон кастодианаас бусад этгээдэд төлөх төлбөр;
 - Татан буулгах үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээдэд уг ажиллагаатай холбогдох зардал буюу Хорооноос томилогдсон этгээд татан буулгах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа бол уг этгээдэд олгох ажлын хөлс;
 - Хөрөнгө хадгалах гэрээний дагуу кастодианд төлөх үйлчилгээний төлбөр;
 - Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйлчилгээний төлбөр;
- Эдгээр өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн хөрөнгийг нэгж эрх эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн олгоно.

3.12 САН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ БОЛОХ АЛДАГДАЛ ХҮЛЭЭХ ТОХИОЛДОЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

"Ашид Арвижих" хамтын хөрөнгө оруулалтын санг дараах тохиолдолд төлбөрийн чадваргүй болсон эсхүл алдагдал хүлээх магадлалтай болсон гэж үзэн, ажлын 15 хоногийн дотор нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны явцад Сангийн цэвэр активийн хэмжээ нь дараалсан 10 хоногын туршид тухайн сан үйл ажиллагаагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40 хувь, эсхүл түүнээс илүү хэмжээгээр буурсан, үүнтэй холбоотойгоор Хөрөнгө Оруулалтын Менежментийн Компани (цаашид ХОМК гэх) ажлын 15 өдөрт багтаан Нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулсан боловч хурлаар Сангийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, эрсдэлийг хүлээн зөвшөөрөх шийдвэр гаргасан;

- Сангийн активт тавих шаардлага, зохистой харьцааны шалгуурыг хангахгүй 45 ба түүнээс дээш өдөр болсон;



- Сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг болон нэгж эрхийн танилцуулгад заасан шалгуур үзүүлэлтүүдийн хангахгүй 45 ба түүнээс дээш өдөр болсон;

- Хорооны хяналт шалгалтаар төлбөрийн чадвар муудаж байгаа нь тогтоогдож, арга хэмжээ авч хэвийн нөхцөлд оруулалгүй 45 ба түүнээс дээш хоносон;

Дээрх нөхцөл байдал үүссэн бол Сангийн үйл ажиллагаанд эрсдэл нөхцөл байдал үүссэн гэж үзэн, нэгж эрх эзэмшигчдийн хурлаас бүрэн эрхт төлөөлөгч томилон дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:



- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг тодорхой хугацаанд түдгэлзүүлж, ХОМК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний төлбөрийг зогсоох;

- Шаардлагатай тохиолдолд бүрэн эрхт төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдлагаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг томилох;

- Бүрэн эрхт төлөөлөгчийн (зөвлөлийн гишүүд хамаарна) ажлын удирдамжийг батлах;

- Бүрэн эрхт төлөөлөгчид туслах ажлын хэсгийн удирдамжийг батлах

- Эрсдэлт нөхцөл байдал үүсэн тохиолдолд Кастодиан банк болон Хороонд мэдэгдэнэ;



“АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГА



4. “АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА



4.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан журмууд, Сангийн хөрөнгө оруулалтын бодлогод заасан хязгаарлалт, хөрөнгө оруулалтын зохистой харьцаанаас гадна доорхи эрсдэлийн удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлж хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулна:

4.1.1 Сангийн хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулахын тулд өмчлөлийн хэрэгсэлд оруулах хөрөнгийн нийт хэмжээ нь Сангийн нийт активын 70 /дал/ хувиас хэтрэхгүй байх ба өмчлөлийн хэрэгсэлд оруулах хөрөнгөд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.5, 26.1.8-д заасан хөрөнгө оруулалтын хэрэгслийг оруулна.

4.1.2 Засгийн газар, нийслэл болон компанийн өрийн хэрэгслүүдэд оруулах хөрөнгийн нийт хэмжээ нь Сангийн нийт активын 20 /хорь/ хувиас багагүй 30 /гуч/ хувиас ихгүй байна.

4.1.3 Банкны хадгаламжийн бүтээгдэхүүн, бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд оруулах хөрөнгийн нийт хэмжээ нь Сангийн нийт активын 10 /арав/ хувиас хэтрэхгүй байна.

4.1.4 Банкны салбарын хувьцаанд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нь нийт активын 25 /хорин тав/ хувиас хэтрэхгүй байна.

4.1.5 Хорооноос гаргасан Хамтын сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ХОС-н нийт активын 20 /хорь/ болон түүнээс дээш хувийг хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий арилжааны банкны хадгаламж, эсхүл харилцах дансанд байршуулахыг хориглоно; Ингэхдээ хэрэв тухайн банкны гаргасан үнэт цаасыг Сан эзэмшиж байгаа бол тэдгээрийн үнийн дүнг нэмж тооцно.

4.1.6 Тухайн сангийн нийт активын 10 /арав/ болон түүнээс дээш хувьтай тэнцэх

хэмжээний хөрөнгийг 1 /нэг/ үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасанд оруулахыг хориглоно.

4.1.7 Аливаа хуулийн этгээдийн нийт гаргасан үнэт цаасны 10 /арав/ болон түүнээс дээш хувийн үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх буюу нийт саналын эрхийн 10 /арав/ ба түүнээс дээш хувийг дангаар эзэмшихийг хориглоно.

4.1.8 Сангийн менежер Сангийн нийт активын 5 /тав/ хувь хүртэлх хэмжээтэй хөрөнгө оруулалтыг бие даан шийдвэр гаргаж, хөрөнгө оруулах эрхтэй.

4.1.9 Сангийн үйл ажиллагааны явцад Сангийн цэвэр активын хэмжээ нь дараалсан календарын 10 /арав/ хоногийн туршид тухайн сан үйл ажиллагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40 /дөрвө/ хувь, эсхүл түүнээс илүү хэмжээгээр буусан нөхцөлд тухайн ХОМК нь ажлын 15 /арван тав/ өдөрт багтаан Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна.

4.1.10 Хөрөнгө оруулалтын бүх хэрэгслүүдийг хөрвөх чадварын зэргээр нь 4 /дөрөв/ ангилна. Үүнд: хөрвөх чадвар сайн, дунд зэргийн хөрвөх чадвартай, хөрвөх чадвар сул болон хөрвөх чадвар муу гэсэн ангиллууд байна. (highly liquid, moderate liquid, less liquid, illiquid asset)

4.1.11 Сангийн нийт активын 10 /арав/ хувиас дээш хөрөнгийг хөрвөх чадвар муу ангиллын хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно.

4.1.12 Сангийн цэвэр активын үнэлгээ /NAV/-ийг өдөр тутам тооцно. Харин хөрөнгө оруулалтын багцын зохистой харьцаа, багцын стандарт хазайлт, sharpe ratio, стресс тестүүд, нэгж эрх эзэмшигчийн цэвэр хөрөнгө (net subscription ratio) болон хөрвөх чадварын үзүүлэлт зэргийг сард 1 /нэг/ удаа шинэчлэн тооцож, ТУЗ-н хуралд танилцуулна.

4.1.13 Хэрэв сангийн нийт активын 10 /арав/ хувиас дээш хувийг хөрвөх чадвар

муутай хэрэгсэлд хөрөнгө оруулсан бол календарын 30 /гуч/ хоногт багтаан хөрвөх чадварыг заасан төвшинд аваачих бөгөөд, дараагийн ТУЗ-н хуралд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тайлагнана.

4.1.14 Хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрээр хөрөнгө оруулалтын бодит үнэ цэн (БҮЦ)-ийг тооцох аргачлалыг хэрэгжүүлнэ. Хувьцааны хувьд БҮЦ-г өмнөх өдрийн хаалтын ханшаар, Бондын хувьд БҮЦ-г өртгөөр нь, Харин мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн БҮЦ-г хуримтлагдсан хүүг нэмсэн байдлаар тооцно.

4.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөрөнгө оруулалтын сан нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Хамтын сангийн үйл ажиллагааны журам"-н дагуу үйл ажиллагааг зохион байгуулна. Бидний тооцоолж байгаагаар сангийн үйл ажиллагаатай холбоотой доорхи төрлийн эрсдэлүүд үүсэж болно:

- Технологи, тоног төхөөрөмжийн эрсдэл
- Мэдээлэл, хадгалалт, аюулгүй байдлын эрсдэл
- Боловсон хүчний эрсдэл
- Засаглалын эрсдэл

Иймд эдгээр эрсдэлийг хянах, удирдахаар доорхи арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

4.2.1 Сан нь хөрөнгө оруулалтыг хялбаршуулах, хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны процессийг хялбаршуулах, үйл ажиллагааны зардлыг бууруулах зорилгоор онлайн плафформ болон гар утасны аппликейшн хөгжүүлж байна. Иймд бид тус платформын мэдээллийн аюулгүй байдал, үйл ажиллагааны үр дүнтэй байдал, эрсдэл зэрэгт IT системийн аудит хийлгэнэ.

4.2.2 Уг аудитыг платформыг хөгжүүлж дууссаны дараа нэг удаа бөгөөд, цаашид ноцтой алдаа гарах, эсвэл нэмэлт хөгжүүлэлт хийлгэсэн зэрэг шаардлагатай нөхцөлд дахин хийлгэнэ.

4.2.3 Боловсон хүчний эрсдэлийг бууруулах зорилгоор Хөрөнгө оруулалтын албандажиллах бүх ажилтан, мэргэжилтнийг МҮЦАЭХ-ноос явуулдаг Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сургалтанд

хамруулж, гэрчилгээ эзэмшүүлсэн байна.

4.2.4 Хорооноос батласан Хамтын сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ХОМК-с томилсон сангийн менежер нь мэргэжлийн хариуцлагын даатгалд зайлшгүй хамрагдана. Иймд сангийн менежерийн гаргасан санамсар, болгоомжгүй алдаа, түүнээс улбаалан Санд учрах тодорхой хэмжээний хохирлыг даатгалаар нөхөн төлүүлэх боломжтой.

4.2.5 ХОМК-ын ажилчид жилд нэг удаа ёс зүйн тайлан, комплайнс тайлан гарган, үйл ажиллагааны тайланд хавсаргана.

4.2.6 Сангийн зардлын төрөл, зардал тус бүрийн дээд хэмжээг "Хөрөнгө оруулалтын сангийн зардлын зүйл, дээд хэмжээг тогтоох журам"-аар зохицуулна.

4.2.7 Сангийн үйл ажиллагааг явуулахад зайлшгүй шаардлагатай, дээд хаязгаараас хэтэрсэн зардлыг Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлнэ.

4.3 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

"Ашид Арвижих" хамтын хөрөнгө оруулалтын сан нь нээлттэй сан болохын хувьд нэгж эрх эзэмшигчдийн өмнө гаргасан нэгж эрхээ буцаан худалдан авах үүргийг хүлээдэг. Иймд нэгж эрхийн буцаан авалт, ногдолашиг тараалт, үүнтэй холбоотой мөнгөн хөрөнгийн хэрэгцээ шаардлага болон хөрвөх чадварын эрсдэлийг үр дүнтэй удирдах төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Хөрвөх чадварын болон нэгж эрх эзэмшигчдийн эрсдэлийн удирдлагын хүрээнд доорхи эрсдэлийн удирдлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна:

4.3.1 ХОМК нь календарын 14 /арван дөрөв/ хоногт нэг удаа ТУЗ-д сангийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа болон нэгж эрх эзэмшилтэй холбогдох тооцоолол, судалгааг бүрэн танилцуулна.

4.3.2 Сан жил бүрийн цэвэр ашгийн тодорхой хувийг ногдол ашиг болгон хуваарилах бөгөөд шийдвэрийг ТУЗ гаргана. Ингэхдээ "Сангийн орлогоос нэгж эрх эзэмшигчдэд орлого хуваарилах нөхцөл, журам"-аар тухайлан зохицуулна.

4.3.3 Нэгж эрх худалдан авах, буцаан худалдах ажиллагааг сангийн онлайн платформ болон гар утасны аппликейшнээр




дамжуулан зохион байгуулах ба ингэхдээ "Сангийн нэгж эрхийг худалдан авах, буцаан худалдах, захиалга өгөх журам"-ын дагуу тухайлан зохицуулна.

4.3.4 Нэгж эрхийг буцаан худалдах захиалгыг эдийн засаг, улс төр болон хууль эрхүйн гэнэтийн, онцгой нөхцөл байдал түр хугацаагаар зогсоож болох бөгөөд, гүйцэтгэх удирдлага уг саналыг ТУЗ-д танилцуулж, ТУЗ-ийн шийдвэрээр хэрэгжүүлнэ.

4.3.5 Нэг удаагийн захиалгаар Сангийн цэвэр активын 10 /арав/ хувиас ихгүй хэмжээний нэгж эрхийг буцаан худалдах хүсэлтийг хүлээж авна. Түүнээс хэтэрвэл хувь тэнцүүлэх байдлаар буцаалтын захиалгыг хүлээн авч биелүүлэх бөгөөд үлдсэн биелээгүй захиалгыг хүчингүй гэж тооцох бөгөөд биелүүлэх үүрэг үүсэхгүй болно.

4.3.6 Нэгж эрх эзэмшигч нь нэгж эрхийг анх худалдан авснаас 1 /нэг/ сарын хүлээлгийн хугацаатай байх бөгөөд нэгж эрхийг санд буцаан худалдах ажиллагааг "Сангийн нэгж эрхийг худалдан авах, буцаан худалдах, захиалга өгөх журам"-аар зохицуулна. Энэ нь хөрөнгө оруулалтын сангийн өгөөжийг тогтмол байлгах, Сангийн хөрвөх чадварыг хангах, Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах зорилготой зохицуулалт болно.

ТУЗ, Дотоод хяналтын хороо болон Гүйцэтгэх удирдлага нь үйл ажиллагааны бүх төвшинд эрсдэлийн хяналт, удирдлагын сайн тогтолцоо, соёлыг бий болгохоор бүх хүчин чармайлтыг гарган ажиллана.



“АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ
ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА



5. “АШИД АРВИЖИХ” ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА

“Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын сан нь 500'000'000 /таван зуун сая/ ширхэг зарласан нэгж эрхтэй байх бөгөөд Санг үүсгэн байгуулах баримт бичиг, нэгж эрхийн танилцуулгыг Хороонд бүргүүлснээс хойш 3 сарын хугацаанд олон нийтэд танилцуулж, 1 сарын хугацаанд 10'000'000

/арван сая/ ширхэг нэгж эрхийг нэг бүрийг нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнээр анхдагч зах зээлийн арилжаанд гаргаж 1'000'000'000 /нэг тэрбум/ төгрөг татан төвлөрүүлж, тусгай зөвшөөрөл авснаар үйл ажиллагаагаа эхлүүлнэ.

Нэгж эрх гаргагч	“Ашид Арвижих” хамтын хөрөнгө оруулалтын сан
Зарласан нэгж эрхийн тоо	500'000'000 /таван зуун сая/ ширхэг
Анхдагч зах зээлийн арилжааны нэгж эрхийн нэрлэсэн үнэ	100 /нэг зуу/ төгрөг
Анхдагч зах зээлийн арилжаагаар гаргах нэгж эрхийн тоо	10'000'000 /арван сая/ ширхэг
Анхдагч арилжаагаар олон нийтэд санал болгож буй нэгж эрхийн тоо	9'500'000 /есөн сая таван зуун мянга/ ширхэг
Анхдагч арилжаагаар гаргасан нэгж эрхэд эзлэх хувь	95%
Анхдагч арилжаагаар олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	950'000'000 /есөн зуун тавин сая/ төгрөг
Хөрөнгө оруулалтын хэлбэр	Зөвхөн мөнгөөр
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт	Хөрөнгө оруулалт
Нэгж эрхийн үнийг санал болгох хэлбэр	Тогтоосон үнийн аргаар
Арилжааг зохион байгуулагч	“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК Сангийн онлайн платформ
ХОС үүсгэн байгуулагч	“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК.

“Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын сан нь нэгж эрхээ бусдад худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр зарласан нэгж эрхээс хөрөнгө оруулагчдад худалдах бөгөөд Сангийн үйл ажиллагаа явуулах нийт хугацаанд нийт 42.7 /дөчин хоёр аравны долоо/ тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлж ажиллахаар төлөвлөж байна. Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагын

дагуу Сангийн гаргасан нэгж эрхийн 5 /тав/ хувийг санг үүсгэн байгуулагч ХОМК буюу “Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК өөрийн хөрөнгөөр эзэмших бөгөөд, үлдсэн 95 /ерэн тав/ хувийг олон нийтэд байнга санал болгож эрэлтийн хэмжээгээр арилжина.

“Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулахыг хүсж буй хөрөнгө оруулагч нар хэдийд ч Сангийн онлайн платформ болон гар утасны аппликэйшнээр дамжуулан эсхүл Сангийн

төлөөлөгч нараас зөвлөгөө авч хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулан, нэгж эрх худалдан авах, авсан нэгж эрхээ эргүүлэн санд худалдах боломжтой.

5.1 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ
 “Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх нь сангийн хөрөнгөнөөс өмчлөх хувь хэмжээг гэрчлэх бөгөөд нэгж эрхийн өмчлөгчийн зүгээс ХОМК-с Сангийн хөрөнгийг Сангийн дүрэм болон хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд мэргэжлийн төвшинд зохих ёсоор удирдахыг шаардах, Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд нэгж эрх тус бүрээр саналын нэг эрхтэйгээр оролцох, Санг татан буулгах үед өөрт ногдох хөрөнгийн хүлээн авах эрхийг гэрчилнэ.

“Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын санд хувь хүн, хуулийн этгээдийн аль аль нь хөрөнгө оруулж, нэгж эрх эзэмшигч болох боломжтой.

Сангийн нэгж эрх эзэмшигч нь дараах эрх үүрэгтэй байна. Үүнд:

1. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн нэгж эрхийн тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;

2. Сангийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр өөрийн эзэмшлийн нэгж эрхийн хэмжээнд болон тэдгээрийг эзэмшиж байгаа хугацаанд хувь тэнцүүлэн ногдол ашиг хүртэх;

3. Санг татан буугдах үед өөрт ногдох хөрөнгийг хүлээн авах;

4. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах хүсэлтийг Сангийн менежер, Сангийн төлөөлөн удирдах зөвлөлд гаргах эрхтэй бөгөөд уг хүсэлтэд Сангийн нийт эрх эзэмшигчдийн 5% /таван хувь/ болон түүнээс дээш хувийн нэгж эрх эзэмшигчид ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахыг зөвшөөрснөө баталж, гарын үсэг зурсан байна.

5. ХОМК болон кастодианы Санд үйлчилгээ үзүүлэх ажиллагааг зогсоох, түүнийг өөрчлөх тухай асуудлыг Сангийн төлөөлөн удирдах зөвлөл эсхүл Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх санал гаргах

6. Сангийн нийтэд болон нэгж эрх

эзэмшигчдэд мэдээлэл өгөх журмаар зөвшөөрсөн бүх мэдээллийг авах, танилцах;

7. Өөрийн нэр, оршин суугаа хаяг болон эзэмшиж байгаа нэгж эрхийн тоог нэгж эрх эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх;

8. Сангийн өр төлбөр, бусдаас авсан зээлийг нэгж эрх эзэмшигч өөрийн хөрөнгөөр хариуцахгүй;

9. Сангийн нэгж эрх эзэмшигч өөрийн нэгж эрхийн төлбөрийг төлсөний дараа аливаа төлбөр хийх үүрэг хүлээхгүй;

10. Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан эрх, үүрэг;

5.2 НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛАН ХҮРГҮҮЛЭХ

“Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын сан нь Сангийн “Нийтэд болон сангийн нэгж эрх эзэмшигчдэд мэдээлэл өгөх журам”-ын дагуу олон нийтэд болон нэгж эрх эзэмшигчидээ тухайлсан мэдээллүүдийг хүргэх болно.

“Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын сан өөрийн онлайн платформ болон гар утасны аппликэйшнээр дамжуулан дараах мэдээллүүдийг нийтэд нээлттэй мэдээлэх болно. Үүнд:

1. Сангийн Зарласан нэгж эрхийн төрөл, хэлбэр, үнэ

2. Сангийн нэгж эрхийн танилцуулга

3. Сангийн Танилцуулга

4. Сангийн цэвэр активын үнэлгээ

5. Сангийн цэвэр хөрөнгийн өөрчлөлт, хэрэгжсэн болон хэрэгжээгүй ашиг, алдагдлын тооцоолол, удирдлагын зардал, сангийн нэгж эрх эзэмшигчдэд төлсөн ногдол ашиг, сангийн хөрөнгийн дэлгэрэнгүй бүтэц зэрэг мэдээллийг агуулсан сангийн үйл ажиллагааны тайлан

6. Тухайн жилийн цэвэр ашгаас сангийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр

7. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны тухай хуульд заасан бусад мэдээллийг тухай бүрт мэдээллэнэ.

“Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн эрх барих дээд байгууллага болох нэгж эрх эзэмшигчдийн

хуралд мэдээлэх мэдээлэл нь Сангийн дотоод мэдээлэлд хамаарна. Үүнд:

1. Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын болон жилийн тайлан
2. ХОМК-ийн үйл ажиллагааны тайлан
3. Сангийн менежерийн эрсдэлийг тооцоолсон тооцоолол
4. Кастодианы үйл ажиллагааны тайлан, дансны хуулбар
5. Үнэлгээчинтэй байгуулсан гэрээ, танилцуулга
6. Дотоод хяналтын хорооны дүгнэлт

5.3 НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

"Ашид Арвижих" Хамтын хөрөнгө оруулалтын сан нь Нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн хувьд нэгж эрхээ бусдад худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр зарласан нэгж эрхээс хөрөнгө оруулагчдад худалдаж, гаргасан нэгж эрхээ Сангийн дүрэм болон журмын дагуу эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг онцлогтой сан юм. Сангийн нэгж эрхийн арилжааг ХОМК-ийн онлайн платформ болон гар утасны аппликэйшнээр дамжуулан явуулна. Сангийн нэгж эрхийн арилжаа нь анхдагч болон хоёрдогч арилжаа гэсэн хэлбэртэй байна.

5.3.1 Анхдагч арилжаа

Анхдагч арилжаа нь уг нэгж эрхийн танилцуулгыг Хороонд бүртгүүлж олон нийтэд танилцуулах зөвшөөрөл авсаны дараа явагдах бөгөөд Сангийн анхдагч арилжаанд гаргаж буй 10'000'000 /арван сая/ ширхэг нэгж эрх тус бүрийг 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнээр олон нийтэд арилжиж, 1'000'000'000 /нэг тэрбум/ төгрөгийг татан төвлөрүүлнэ.

Анхдагч арилжааны үе шатууд:

1. Ашид Ассет Менежмент ҮЦК ХХК-ийн гар утасны апп болон ashidasset.mn онлайн платформд хандан харилцагчаар бүртгүүлж, баталгаажуулалт хийлгэх
2. Хөрөнгө оруулагчын зан төлөвийг тодорхойлох тест бөглөж, өөрийн хөрөнгө оруулалтын чадамж, зан төлөвөө тодорхойлуулах
3. Сангийн нэгж эрх худалдан авах захиалга байршуулж, баталгаажуулах
4. Уг захиалгын дагуу Сангийн

хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ бүтээх бөгөөд гэрээний нөхцөлтэй танилцах, гэрээ байгуулах


5. Сангийн кастодиан банкн дахь дансанд хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан мөнгөн дүнг шилжүүлэх
Дээрх үе шатуудын дагуу нийт гаргасан нэгж эрхийн захиалга дүүрч, кастодиан банканд мөнгө байршсаны дараа хөрөнгө оруулагч тус бүрт ногдох нэгж эрхийн тоо ширхэг, холбогдох гэрээг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, Хороо зөвшөөрснөөр нэгж эрхийн тухайлсан бүртгэл хийгдэж, үнэт цаасыг хөрөнгө хадгалж буй кастодиан банкны дансанд хадгалж, анхдагч арилжаа амжилттай болсон гэж үзнэ. Хөрөнгө оруулалтын сангийн анхдагч захиалгын үед хөрөнгө оруулагчдаас арилжааны шимтгэл авахгүй. Мөн анхдагч арилжаанд гаргасан нэгж эрхийн тооноос илүү гарсан захиалгыг биелүүлэхгүй бөгөөд хоёрдогч арилжааруу шилжүүлэх хүсэлтийг хөрөнгө оруулагчдад тавина.

5.3.2 Хоёрдогч арилжаа

Сангийн анхдагч арилжаа амжилттай биелж, 1'000'000'000 /нэг тэрбум/ төгрөгийг татан төвлөрүүлснээр Хорооноос Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, Сангийн үйл ажиллагааг эхлүүлнэ. Сан нь нэгж эрхээ бусдад худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр зарласан нэгж эрхээ худалддаг, гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг тул уг харилцааг хоёрдогч арилжаагаар зохицуулна.

Сан нь нээлттэй сан тул шинээр хөрөнгө оруулагчдад нэгж эрх арилжих үед Санд аль хэдийн хөрөнгө оруулсан нэгж эрх эзэмшигчдийн эрх ашиг, хөрөнгийн үнэлгээг хамгаалах, Санд нэгж эрхээ буцаан зарж хөрөнгө оруулалтаа татах үед Санд үлдэж буй хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн үнэлгээг хамгаалах, тэдгээртэй холбоотой Сангийн хөрвөх чадвар, хөрөнгийн зохистой харьцааг хадгалж, хөрөнгийг үр ашигтай удирдах нь нэн тэргүүний чухал асуудал юм.

Нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн хувьд Сангийн нэгж эрхийн үнэлгээ нь Сангийн цэвэр хөрөнгө буюу **Net Asset Value /NAV/**-д суурилсан байдаг. Харин Санд шинээр хөрөнгө оруулалт хийх эвсэл Сангаас



хөрөнгө оруулалт татах зэрэг нь Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ /NAV/-д нөлөөлж, Сангийн нэгж эрх эзэмшигчдийн нэгж эрхийн үнэлгээнд нөлөөлж байдаг. Энэхүү нөлөөг **Dilution effect** гэр нэрлэдэг. Санд нэмж хөрөнгө оруулалт хийх эсвэл Сангаас хөрөнгө оруулалтаа татах хүсэлтийг биелүүлэхийн тулд Сан нэмж хөрөнгө оруулалтын хэрэгсэл худалдаж авах эсвэл ба хөрөнгө оруулалтын хэрэгсэлээ худалдах хэрэгтэй болдог. Энэхүү худалдаж авах эсвэл зарах явцад арилжааны шимтгэл, брокерийн шимтгэл, Биржийн авж зарах ханшийн зөрүү гэх мэт зардлууд Сангаас гардаг учир Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ /NAV/-д нөлөөлдөг. Энгийнээр хэлвэл Санд шинээр хөрөнгө оруулалт хийх эсвэл хөрөнгө оруулалтаа татах нь Сангийн Цэвэр хөрөнгийн үнэлгээнд нөлөөлдөг байна. Тиймээс Сангийн менежерүүд энэхүү **dilution effect**-с Санд үлдэж буй хөрөнгө оруулагчдыг хамгаалахын тулд **anti-dilution** аргуудыг ашиглах хэрэгтэй болдог. **Anti-dilution levy** ба **swing pricing** гэх аргууд нь хамгийн өргөн хэрэглэгддэг хэрэглүүрүүд юм. **Anti-dilution levy** нь Санд шинээр орж ирж байгаа болон Сангаас гарж байгаа хөрөнгө оруулагчдад тогтмол дүнгээр шимтгэл ногдуулдаг ба **Swing pricing** нь Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээг тухайн арилжааны зардлын хэмжээгээр бууруулж тооцоолж, нэгж эрхийн үнэ тогтоодог арга юм. Үүнтэй холбоотойгоор бид Дэлхийн 130 гаруй улс орнууд өөрсдийн хөрөнгө, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаандаа зөвлөмж авч ажилладаг IOSCO (**International Organization of Securities Commissions**)-ийн заавар зөвлөмж, зорилтуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахаар зорьсон. Бид IOSCO-с эрхлэн гаргадаг "Нээлттэй сангийн Хөрвөх чадвар болон Эрсдэлийн удирдлагын сайн туршлагаууд ба анхаарах асуудлууд" (**Open-ended fund liquidity and risk management – Good practices and issues for consideration**) цувралуудаас Европын холбооны орнуудын UCITS сангууд, ALFI-ийн сангууд, АНУ, Хонгконг, Япон, Австрали зэрэг орнуудын нээлттэй сангуудын сайн туршлагауудыг судалж, өөрсдийн нөхцөл байдалд тулгуурлан Сангийн хөрвөх чадвар, эрсдэлийн удирдлагын арга хэрэгслүүдийг сонгон авсан болно. Эдгээр орнуудын туршлага, арга барил, сангийн хөрвөх

чадвар болон эрсдэлийн удирдлагын хэрэглүүрүүдийг хэрхэн ажилладаг тухай судалдсан судалгааны тайланг Бизнес төлөвлөгөө боловсруулсан судалгааны тайлан хэсгээс дэлгэрэнгүй уншина уу.

Нэгж эрх худалдан авах

Сан нь зарласан нэгж эрхээ хөрөнгө оруулагчдад худалдахаар байнга санал болгохдоо Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ болон Сангийн нэгж эрхийн үнийг өдөр бүр шинэчлэн тооцоолж, өөрсдийн **ashidas-set.mn** онлайн плафформ болон гар утасны аппликэйшнээр олон нийтэд зарлана. Нэгж эрх худалдан авах үе шат:

1. Сангийн нэгж эрхийг худалдан авах захиалгыг өгөх, баталгаажуулах
 2. Уг захиалгын дагуу Сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ үүсэх бөгөөд гэрээний нөхцөлтэй танилцаж, гэрээ байгуулах
 3. Сангийн кастодиан банкан дахь дансанд хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан мөнгөн дүнг шилжүүлэх
- Хөрөнгө оруулагч нь нэгж эрхийг худалдан авах гэрээг байгуулж, нэгж эрхийн төлбөрийг бүрэн төлснөөр Сангийн нэгж эрх эзэмшигчээр нэгж эрхийн тухайлсан бүртгэлд бүртгэгдэж, Сангийн дүрэм болон бусад хууль тогтоомжид заасан нэгж эрх эзэмшигчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Нэгж эрхийн төлбөр баталгаажиж, нэгж эрхийн тухайлсан бүртгэл хийгдсэний дараа **ashidaset.mn** онлайн платформ дээрх хөрөнгө оруулагчийн өөрийн эзэмшиж буй нэгж эрх гэсэн хэсэгт нэгж эрхийн мэдээлэл харагдана.

Хоёрдогч арилжаагаар Санд шинээр 50'000'000 /тавин сая/ төгрөг хүртэлх хөрөнгө оруулж буй хөрөнгө оруулагчдаас 2% шимтгэл буюу **anti-dilution levy**-г өгсөн захиалгын үнийн дүнгээс суутган авна. 50'000'000 /тавин сая/ төгрөгөөс дээш дүнгээр хөрөнгө оруулж буй хөрөнгө оруулагчдын шимтгэлийг Сангийн менежер тухай бүр тогтооно. Хэрэв шинэ хөрөнгө оруулагч нэгж эрх авж, нэгж эрх эзэмшигч болвол тухайн хөрөнгөөр Сангийн менежер нэмж хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй болдог. Энэ үед ахиад зардал гарах бөгөөд энэ зардлыг тухайн хөрөнгө оруулагчаас шимтгэл хэлбэрээр урьдчилан суутган авах

замаар Санд аль хэдийн хөрөнгө оруулсан нэгж эрх эзэмшигчдийн эрх ашиг, хөрөнгийн үнэлгээг хамгаалах зорилготой.

Нэгж эрх буцаан худалдах

Сан нь нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн хувьд гаргасан нэгж эрхээ хууль тогтоомж болон сангийн дүрэм, журамд заасан нөхцлөөр буцаан худалдаж авах үүрэг хүлээнэ. Сангийн нэгж эрхийг буцаан худалдан авахдаа Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ болон Сангийн нэгж эрхийн үнийг өдөр бүр шинэчлэн тооцоолж, өөрсдийн ashidasset.mn онлайн плафтом болон гар утасны аппликэйшнээр олон нийтэд зарлана.

Нэгж эрх буцаан худалдах үе шат:

1. Сангийн нэгж эрхэд хүлээлгийн хугацаа */lockup period/* гэж байх ба энэ нь тухайн нэгж эрхийг худалдан авснаас хойш 1 /нэг/ сар байна. Хүлээлгийн хугацаа дууссан нэгж эрхийг Санд буцаан худалдах боломжтой, хүчинтэй захиалга гэж үзнэ.

2. Сан энэхүү хүлээлгийн хугацаанд хамаарах нэгж эрхийг буцаан худалдах захиалгыг биелүүлэхдээ нэгж эрх буцаан худалдан үндсэн шимтгэл дээр нэмэлт 1 /нэг/ хувийн шимтгэл ногдуулж, захиалгыг биелүүлнэ.

3. Сан нь хүлээлгийн хугацаа нь дууссан буюу буцаан худалдах боломжтой нэгж эрхийг Санд буцаан худалдах хүсэлтийг 7 хоногт нэг удаа */notice period/*, Даваа гарагийн 11:00-15:00 (Улаанбаатар хотын цагаар) цагийн хооронд сангийн онлайн платформ болон гар утасны аппликэйшнээр дамжуулан хүлээн авна. Хэрэв тухайн Даваа гариг нь ажлын бус өдөрт таарвал дараагийн ажлын өдөр Захиалга хүлээн авах өдөр байна.

4. Захиалга хүлээн авах өдөр Сангийн нэгж эрхийг буцаан худалдах захиалгыг өгөх, баталгаажуулах

5. Сан нэгж эрхийг буцаан худалдах баталгаажсан захиалгыг ажлын 5 хоногийн дотор биелүүлж, нэгж эрх буцаан худалдан авах төлбөрийг нэгж эрх эзэмшигчид шилжүүлнэ.

Сангийн нэгж эрх буцаан худалдах нэг удаагийн захиалгаар тухайн захиалагч өгөх өдрийн Сангийн цэвэр активын 10%-иас ихгүй

хэмжээний */Redemption gates/* нэгж эрхийг буцаан худалдах хүсэлтийг хүлээж авах, биелүүлэх үүрэгтэй байна. Үүнээс хэтэрсэн нэгж эрхийг буцаан зарах хүчинтэй захиалга ирвэл нийт ирсэн хүчинтэй захиалгыг хувь тэнцүүлэн 10% болгож захиалгыг биелүүлэх бөгөөд үлдсэн биелээгүй захиалгыг хүчингүй гэж үзэж, биелүүлэх үүрэг үүсэхгүй болно. Уг хүчингүй болсон захиалгыг нэгж эрх эзэмшигч нь дахин өгөх боломжтой. Зарим тохиолдолд зах зээлийн онцгой нөхцөл үүссэн үед Сангийн менежер санал гаргаж, Сангийн ТУЗ батласнаар Сангийн нэгж эрхийг буцаан худалдах хүсэлтийг богино хугацаагаар хязгаарлаж */suspension of redemption/* болох бөгөөд ингэхдээ Сангийн "Нэгж эрх худалдан авах, буцаан худалдах, захиалга өгөх журам"-ын дагуу зохицуулна. Нэгж эрх эзэмшигч өөрийн эзэмшлийн, хүлээлгийн хугацаа дууссан нэгж эрхээ Санд буцаан худалдахдаа өөрийн нийт эзэмшиж буй нэгж эрхийн хэдэн хувийг буцаан худалдаж байгаагаас хамааран дараах шимтгэлүүдийг */anti-dilution levy/* Санд төлнө.

Захиалгын үнийн дүн	1 000 000	1 000 000 - 5 000 000	5 000 000
	төгрөг хүртэлх	төгрөг	төгрөгөөс дээш
Шимтгэлийн хэмжээ	2%	3%	4%

Хэрэв хөрөнгө оруулагч нэгж эрхээ буцаан худалдаж сангаас хөрөнгө оруулалтаа татах болвол хөрөнгийг Сангийн менежер худалдаж, бэлэн мөнгө болгох */liquidate/* хэрэгтэй болдог. Энэ үед ахиад зардал гарах бөгөөд энэ зардлыг тухайн хөрөнгө оруулагчаас шимтгэл хэлбэрээр суутган авах замаар Санд үлдэж буй хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн үнэлгээг хамгаалах зорилготой.

5.4 САНГИЙН ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, НЭГЖ ЭРХИЙН ҮНИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

"Ашид Арвижих" Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ */NAV/* болон түүнд суурилсан нэгж эрхийн үнийг Санд хөрөнгө хадгалах үйлчилгээ хадгалах үйлчилгээ үзүүлж буй Голомт банкны Кастодиан банкны хэлтэс болон ХОМК нар өдөр бүр тооцоолж Сангийн онлайн платформ болон гар утасны аппликэйшнээр дамжуулан олон нийтэд

мэдээлэх болно.

Сангийн нэгж эрхийг худалдах, эргүүлэн худалдаж авах ажиллагааг Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээнд /NAV/ суурилсан нэгж эрхийн үнээр явуулах бөгөөд ингэхдээ Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээг дараах байдлаар тооцно.

$$\text{Нэгж эрх эзэмшигчдийн нийт цэвэр хөрөнгө} = \text{Нийт хөрөнгийн бодит үнэ цэн} = \text{Нийт өр төлбөрийн бодит үнэ цэн}$$

Сангийн нэгж эрх эзэмшигчдийн нийт цэвэр хөрөнгө нь Сангийн нийт эзэмшиж буй хөрөнгийн бодит үнэ цэнээс Сангийн нийт өр төлбөрийн бодит үнэ цэнийг хассан цэвэр дүн байна.

Тухайн өдрийн сангийн нийт эзэмшиж буй хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцохдоо дараах байдлаар тооцно. Үүнд:

- Хувьцааны үнэлгээ: Үнэт цаасны арилжааны байгууллагад бүртгэлтэй хувьцааны үнэлгээг тухайн арилжааны байгууллагад арилжаалсан сүүлийн хаалтын ханшинд суурилан гаргана.

- Өрийн хэрэгслийн үнэлгээ: Үнэт цаасны арилжааны байгууллагад бүртгэлтэй өрийн хэрэгслийн үнэлгээг түүний хүүг хуримтлуулан тооцно.

- Бэлэн мөнгө, хадгаламжийн үнэлгээ: Бэлэн мөнгө болон хадгаламжийн үнэ цэнийг тооцохдоо түүний хуримтлагдсан хүүг оруулна.

Сангийн нийт эзэмшиж буй хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцохдоо өдөр бүр тооцоолох боломжгүй зарим төрлийн хөрөнгийн үнэлгээг нэрлэсэн буюу дансны үнээр эсхүл үнэлгээний байгууллагын тодорхойлсноор тооцно.

Сангийн нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгийн дүнг бодитой тооцоолохын тулд Сангийн төлөх ёстой үйлчилгээний хөлсийг өдөрт ногдуулан тооцоолж, бүртгэлд тусгана.

Сангийн нэгж эрхийн үнэ нь нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээг харуулах ба үүнийг доорхи байдлаар тооцоолно.

$$\text{Нэгж эрхийн үнэ} = \frac{\text{Цэвэр хөрөнгийн дүн}}{\text{Гаргасан нэгж эрхийн тоо}}$$

Сангийн нэгж эрхийн үнийг тогтоохдоо Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээг Сангийн гаргасан нэгж эрхийн тоонд хуваана. Сангийн

гаргасан нэгж эрхийн тоог тодорхойлохдоо дараах аргачлалыг мөрдөнө.

Гаргасан нэгж эрхийн тоо	Хугацааны эхэнд гаргасан байсан нэгж эрхийн тоо	Тайлант хугацаанд нэмж гаргасан нэгж эрхийн тоо	Тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан
--------------------------	---	---	---

Сангийн гаргасан нэгж эрхийн тоог тооцохдоо Сангийн анхдагч арилжаагаар гаргасан нэгж эрхийн тоон дээр тухайн хугацаан нэмж гаргасан нэгж эрхийн тоог нэмж, тухайн хугацаанд эргүүлэн худалдан авсан нэгж эрхийн тоог хасах байдлаар тооцно.


5.5 ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ашид Арвижих” Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын сан нь анхдагч зах зээлийн арилжаагаар 10'000'000 /арван сая/ ширхэг нэгж эрхийг нэг бүрийг нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнээр арилжаанд гаргаж 1.0 /нэг/ тэрбум төгрөг татан төвлөрүүлж, тусгай зөвшөөрөл авснаар үйл ажиллагаагаа эхлүүлнэ.

Сан нь хамтын нээлттэй сан учир нэгж эрхээ бусдад худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр зарласан нэгж эрхээс олон нийтэд худалдах бөгөөд 2022 оны эцэст сангийн нийт удирдаж буй татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 10.0 /арван тэрбум/ тэрбум төгрөг, Сангийн үйл ажиллагаа явуулах хугацааны эцэст нийт удирдаж буй хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 42.7 /дөчин хоёр аравны долоо/ тэрбум төгрөг байна.

Санг үүсгэн байгуулахтай холбоотой нэг удаагийн зардлууд гарахтай холбогдон Сангийн цэвэр хөрөнгө 2022 оны эцэст 10.1 тэрбум төгрөг байх бөгөөд жил бүр дунджаар 27.8% өсөж 2031 оны эцэст 103 тэрбум төгрөг байхаар төлөвлөж байна.

Зураг 15 Сангийн цэвэр хөрөнгийн төлөвлөгөө






5.6 НЭГЖ ЭРХИЙН ӨГӨӨЖИЙН ТООЦООЛОЛ

"Ашид Арвижих" Хамтын Нээлттэй хөрөнгө оруулалтын сан нь анхдагч зах зээлийн арилжаагаар нэгж эрх нэг бүрийг 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнээр арилжих бөгөөд 2022 оны эцэст Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээнд суурилсан нэгж эрхийн үнэлгээ 103.2 төгрөг байх бол 2031 оны эцэст 378.0 төгрөг байхаар төлөвтэй байна.

Энэхүү нэгж эрхийн үнэлгээ нь ногдол ашиг тараагаагүй үеийн Сангийн нийт хөрөнгөөс Сангийн нийт өр төлбөрийг хасаж тооцсон буюу аливаа хэлбэрийн зардал, татвар, шимтгэлийн дараах дүнгээс тооцсон дүн болно. Сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа буюу 10 жилийн хугацаан дахь Сангийн нэгж эрхийн жилийн дундаж өгөөж /CAGR/ нь 15.02% байна.

Энгийнээр хэлвэл таны хөрөнгө оруулсан 100 төгрөг зардал, шимтгэл, татвар хассаны дараах дүнгээр жил бүр тогтмол 15.02% өсөж, 10 жилийн дараа 3

Зураг 16 Сангийн нэгж эрхийн үнэлгээний төлөвлөгөө



“АШИД АССЕТ МЕНЕЖМЕНТ
ҮЦК” ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН
ТАНИЛЦУУЛГА





6. “АШИД АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

6.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэр	“Ашид ассет менежмент ҮЦК” ХХК
Компанийн хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Регистрийн дугаар	6742491
Улсын бүртгэлийн дугаар	9011830470
Үйл ажиллагааны чиглэл	Хөрөнгө оруулалтын менежмент
Үйл ажиллагаа явуулах хугацаа	Хугацаагүй
Хувьцаа эзэмшигч	Ашид Финтек Инвестмент Сервис ХХК
Гүйцэтгэх захирал	А.Батпүрэв
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сити тауэр, 1001 тоот
Санд эзэмших нэгж эрхийн хувь хэмжээ	5%

“Ашид ассет менежмент ҮЦК” ХХК нь 2021 оноос хойш Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна. Менежментийн компани нь Санг үүсгэн байгуулах, Сангийн нэгж эрхийг олон нийтэд байнга санал болгож,

хөрөнгө татан төвлөрүүлэх, Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу Сангийн хөрөнгийг үр ашигтай удирдах зэрэг үйлчилгээг мэргэжлийн төвшинд үзүүлэх бөгөөд дээрх үйлчилгээнүүдийг Нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус байдлаар хүргэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО | MISSION

Хүн бүрийг хөрөнгө оруулагч болгож хамтын үнэ цэнийг бүтээнэ.

Building shared value, helping everyone to be an investor.

АЛСЫН ХАРАА | VISION

Хүртээмжтэй, хялбар, хариуцлагатай үйлчилгээг хөгжүүлэх замаар оролцогч талуудын итгэлийг хүлээсэн Нөлөөллийн хөрөнгө оруулалтын тэргүүлэгч компани болно.

A leading impact investing company that is trusted by all stakeholders in its commitment to develop inclusive, simple(easy) and responsible investment management services.

НӨЛӨӨЛЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ / IMPACT INVESTMENT

Хөрөнгө оруулалтыг зөвхөн ашгийн төлөө хийдэг гэх ойлголт ард хоцроод багаггүй хугацаа өнгөрч байна. Сүүлийн үеийн хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүд дан ганц санхүүгийн өгөөж бус нийгэм, байгаль орчинд хүртэл эерэг нөлөөллийг бий болгох хөрөнгө оруулалтыг хийх хандлага, сонирхол нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл, таны хөрөнгө оруулалтын тодорхой хувь бидний амьдарч буй орчин, нийгэм, байгаль, дэлхийд эерэг нөлөө авчрах, үнэ цэнэ бий болгох компаниудад хөрөнгө оруулалт болж очно.

Нөлөөллийн хөрөнгө оруулалтын салбарт нийгмийн хариуцлагыг гухамсарладаг компаниудын өсөлт, нөгөө талаас энэхүү өсөлтөөс өгөөж хүртэхийн хажуугаар хөрөнгөнийхөө үнэ цэнийг өөр талаас нь харж байгаа хөрөнгө оруулагчид, мөн эргэн тойрон, байгал орчинд бий болж буй эерэг өөрчлөлт гээд гурван талт өөрчлөлтийг бий болгосоор байна.

Зураг 17 Нөлөөллийн хөрөнгө оруулалт



Хөрөнгө оруулалтын сангаар дамжуулж хөрөнгө оруулалт хийснээр бий болох давуу талууд:

- **ЭНГИЙН** - Та нэгэнт л хөрөнгө оруулалтын санд хөрөнгөө оруулсан л бол таны хийх ажил болсон гэсэн үг. Хамаг л төвөгтэй ажлыг сангийн менежерүүдэд даатгаж болно.

- **МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА** - Хөрөнгө оруулалтын сангийн менежерүүд өдөр тутам санд буй хувьцаа болон бондыг авах болон зарах шийдвэрүүдийг сангийн зорилгын дагуу судалж, гүйцэтгэж байдаг. Тэд таны өмнөөс бүтэн цагаар ажиллаж, судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр шийдвэр гаргадаг.

- **БОСГО БАГА** - Та Тесла компанийн 1 ширхэг хувьцааг авахад таньд 2.7 сая төгрөг хэрэгтэй бол хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулах доод хэмжээ 200,000₮.

- **ХӨРВӨХ ЧАДВАР** - Бусад төрлийн хөрөнгө /үл хөдлөх, машин/, хувьцаа зэрэгтэй харьцуулахад хөрөнгө оруулалтын нэгж эрх нь авах зарахад амархан, шимтгэл багатай байдаг.

• ДИВЕРСИФИКАЦИ


оруулалтын хамгийн чухал зарчим бол диверсификаци буюу эрсдэлийг наараж, бууруулах байдаг. Та нэг компанид хөрөнгө оруулаа гэж бодоход тэр нь дампуурахад таны бүх л хөрөнгө үгүй болно. Харин хөрөнгө оруулалтын сангийн хувьд хөрөнгө оруулсан 100 компанийн нэг нь учир 1% л үгүй болно.

6.2 УДИРДЛАГА, КОМПАНИЙН БҮТЭЦ

Нэгж эрх эзэмшигчид нь нэгж эрхийн тоогоор саналын эрхтэй бөгөөд сангийн менежерийг сонгох, сангийн дүрэмд өөрчлөлт оруулах, санг татан буулгах, Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн гишүүнийг сонгох зэрэг эрхийг эдлэнэ.

ТУЗ нь нэгж эрх эзэмшигчдийн чөлөөт цагт Сангийн эрх барих байгууллага юм. Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулж санал, шаардлагыг хүлээн авч шийдвэрлэх үүрэгтэй. ТУЗ-ийн дэргэд Дотоод хяналтын хороо үйл ажиллагаагаа явуулах бөгөөд хяналтын хорооны гишүүнийг ТУЗ-аас томилно. Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гүйцэтгэх удирдлага, менежментийн баг хэрэгжүүлнэ.

Зураг 18 "Ашид Ассет Менежмент ҮЦК" ХХК-ийн бүтэц



6.3 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

"Ашид ассет менежмент ҮЦК" ХХК-ийн ТУЗ нь 5 гишүүнтэй бөгөөд үүнээс 2 нь хараат бус гишүүн. ТУЗ нь сард нэгээс доошгүй удаа хуралдаж Сангийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд хяналт тавьж ажиллана.

Хүснэгт 12 ТУЗ-ийн гишүүдийн талаарх мэдээлэл

№	ХОМК-ийн ТУЗ-ийн гишүүдийн нэр	Албан тушаал	Мэргэжил
1	У Энхтайван	ТУЗ-ын дарга	Эдийн засагч
2	А Батпүрэв	ТУЗ-ийн гишүүн	Эдийн засагч, Санхүүч
3	Б Цэлмэг	ТУЗ-ийн гишүүн	Бизнесийн удирдлага
4	Ш Түмэнбаяр	ТУЗ-ийн гишүүн	Эдийн засагч
5	Э Баасан	ТУЗ-ийн гишүүн	Бизнесийн удирдлага хэрэглээний математик

“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн дарга У. Энхтайван

2011 онд Японы Мэйкай их сургуулийг эдийн

засагч мэргэжлээр төгссөн бөгөөд Японы Жюүшин ХК-д удирдах төвшин хүртэл дэвшин 11 жил ажилласан туршлагатай. Монголдоо ирээд Гүүдсек ҮЦК ХХК-г хамтран байгуулж одоогоор компанийн гүйцэтгэх захирлын албыг хашдаг чадварлаг эдийн засагч юм

“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн А. Батпүрэв

Монгол Улсын Гадаад харилцааны яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, Юнител групп, Скайтел групп зэрэг төр, хувийн хэвшлийн байгууллагуудад 20 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр эдийн засагчийн хувьд санхүүгийн салбарын хөгжил, нийтийн санхүү ба орлогын менежментийн сэдвээр судалгаа хийдэг бол бизнесийн зөвлөхийн хувьд стратеги удирдлага, маркетингийн чиглэлээр мэргэшсэн. 2004 онд Санхүү, Эдийн Засгийн Дээд Сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр (BBA), 2013 онд Сидней Их Сургуулийг Санхүүгийн эдийн засгийн магистр (Ms.Econ) зэрэгтэй төгссөн, 2019 оноос БНХАУ-ын Эдийн Засаг, Бизнесийн Их Сургуульд Бизнесийн эдийн засгийн докторантаар (PhD candidate) суралцаж буй.

А.Батпүрэв нь Ашид Ассет Менежмент ҮЦК, Инфорум Консалтинг, ШИМТ Боловсрол компаниудын үүсгэн байгуулагч партнер, Монголын Хөрөнгийн Бирж ХК-ын Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн, Санхүүгийн Хүртээмж-Хөгжил Санаачилга ТББ-ын үүсгэн байгуулагч гишүүн.

“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн Б.Цэлмэг

Банк, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр JPMorgan хөрөнгө оруулалтын сан, SMBC aviation capital, Хас банк зэрэг олон улсын томоохон компаниудад 10 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд одоогоор Ашид Ассет Менежмент ҮЦК ХХК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирлын үүргийг гүйцэтгэдэг.

2008 онд Irish American University-г Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгсөж 2016 онд АССА буюу Олон улсын нягтлан бодогч цолыг авсан. Тэрбээр Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны үнэмлэх, мөн Ирландын Банкарүүдын холбоо, Хуульч нарын холбооны тус тус мэргэжлийн үнэмлэхтэй.

“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш. Түмэнбаяр

Санхүүгийн зохицуулах хороо, Хөгжлийн банк, DBM ассет менежмент зэрэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад эдийн засаг, нийтийн бодлогийн чиглэлээр хяналт шалгалт, зөвлөгөө өгөх төвшинд 15 жил ажилласан туршлагатай. Одоогоор “Дөрвөн улирлын ногоон байшин” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэдэг.

2006 онд Орос улсын MGIMO их сургуульд эдийн засгийн бакалавр мэргэжлээр суралцаж төгссөн бөгөөд Японы Хитоцубаши Их сургуульд мэргэжил дээшлүүлж нийтийн бодлого чиглэлээр магистр хамгаалсан.

“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Э.Баасан

Бизнесийн удирдлага чиглэлээр Анод банк, Худалдаа хөгжлийн банк, Юнител групп зэрэг байгууллагуудад удирдах төвшний ажлыг 20 гаруй жил гүйцэтгэж байгаа туршлагатай. Одоогоор Юнител группийн үндсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн албаны захирлын албыг хашдаг. Тэрбээр бизнесийн удирдлага, хэрэглээний математикийн бакалавр зэрэгтэй.

6.4 ДОТООД ХЯНАЛТЫН ХОРОО

“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн дотоод хяналтын хороо нь ХОМК-ийн үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон холбогдох журмын хүрээнд явуулж байгаа эсэхэд хяналт тавьж, үйл ажиллагааны дүгнэлтээ ХОМК-ын ТУЗ-д тайлагнадаг, хяналтын эрх, үүрэг бүхий бие даасан хороо юм. “Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн дотоод хяналтын хороо нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шаардлага хангасан, уг чиглэлд ажлын туршлагатай 3 гишүүнтэй байна. Энэхүү нэгж нь ээлжит болон ээлжит бус шалгалтыг компанийн санхүү, хөрөнгийн удирдлага, дотоод үйл ажиллагаа гэсэн чиглэлүүдээр төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж ажиллана.

Дотоод хяналтын хорооны гишүүн Э. Баасан
 Э. Баасан нь ХОМК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Дотоод үйл ажиллагаанд мөн хяналт тавьж ажиллана. Тэрбээр Бизнесийн удирдлага чиглэлээр Анод банк, Худалдаа хөгжлийн банк, Юнител групп зэрэг байгууллагуудад удирдах төвшний ажлыг 20 гаруй жил гүйцэтгэж байгаа туршлагатай. Одоогоор Юнител группийн үндсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн албаны захирлын албыг хашдаг. Тэрбээр бизнесийн удирдлага, хэрэглээний математикийн бакалавр зэрэгтэй.

Дотоод хяналтын хорооны гишүүн Д. Шийрэв.

Сүү ХК, Тагнуулын ерөнхий газар, Байгал орчин ногоон хөгжлийн яам, Шонхор үнэлгээ зэрэг төр, хувийн хэвшлийн байгууллагуудад аудит, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр

20 жил ажилласан туршлагатай, 2015 онд МНББИнститутаас аудитын үйл ажиллагаа явуулах эрхийг явсан гишүүн юм. Тэрбээр эдийн засагч, математикч мэргэжилтэй.

Дотоод хяналтын хорооны гишүүн Б.Бадамсүрэн

Санхүү Эдийн Засгийн Их сургуулийг 2021 онд санхүү менежментийн мэргэжлээр төгссөн. 2021 онд “Монголын Үнэт Цаас Арилжаа Эрхлэгчдийн Холбоо” ӨЗБ-өөс Монгол Улсын үнэт цаасны зах зээлд Хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх авсан болно. Мөн тус онд Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Даатгалын Зуучлагдын Холбооноос хамтран зохион байгуулсан “Даатгалын зуучлагчийн эрх олгох сургалт”-ын гэрчилгээ авсан болно. 2021 оноос “Нэйшнл Иншуранс Брокерэйж Сервисэс” ХХК-ийн даатгалын мэргэжилтнээр ажиллаж байгаад өнөөдрийн байдлаар “Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК-д дотоод ажилтнаар ажиллаж байна.

6.5 МЕНЕЖМЕНТИЙН БАГ

“Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн менежментийн баг нь санхүү, эдийн засаг болон хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн, туршлагатай мэргэжилтнүүдээс бүрдэх бөгөөд Хөрөнгийн зах зээлийн судалгаа, шинжилгээ боловсруулах, хөрөнгө оруулалтын стратеги тодорхойлох, Хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр мэргэшин ажиллаж байна.

Одоогоор “Ашид Ассет Менежмент ҮЦК” ХХК нь үндсэн 8, гэрээт 10 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ, IT үйлчилгээ, аудитын үйлчилгээ, маркетингийн багуудыг аутсорсинг хийх байдлаар ажиллаж байна.

№	Нэр	Албан тушаал	Мэргэжил
1	А Батпүрэв	Гүйцэтгэх захирал	Эдийн засагч, Санхүүч
2	Б Цэлмэг	Хөрөнгө оруулалт хариуцсан захирал	Бизнес удирдлага, Санхүүч
3	Б Батгариг	Хөрөнгө оруулалтын зөвлөх	Эдийн засагч, Санхүүч
4	Р Сүвдгэрэл	Хөрөнгө оруулалтын зөвлөх	Санхүүч, бизнес зөвлөх
5	Г Ариунзаяа	Зах зээл шинжээч	Санхүүгийн удирдлага
6	Ц Булгансайхан	Дата аналит	Санхүүгийн удирдлага
7	Э Мөнхболд	Санхүүгийн шинжээч	Санхүүгийн удирдлага
8	О Урангоо	Борлуулалт, харилцагчийн үйлчилгээний мэргэжилтэн	Санхүүгийн удирдлага
9	Б Бадамсүрэн	Дотоод хяналтын мэргэжилтэн	Санхүүгийн удирдлага

Гүйцэтгэх удирдлага А. Батпүрэв.

Монгол Улсын Гадаад харилцааны яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, Юнител групп, Скайтел групп зэрэг төр, хувийн хэвшлийн байгууллагуудад 20 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр эдийн засагчийн хувьд санхүүгийн салбарын хөгжил, нийтийн санхүү ба орлогын менежментийн сэдвээр судалгаа хийдэг бол бизнесийн зөвлөхийн хувьд стратеги удирдлага, маркетингийн чиглэлээр мэргэшсэн. 2004 онд Санхүү, Эдийн Засгийн Дээд Сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр (BBA), 2013 онд Сидней Их Сургуулийг Санхүүгийн эдийн засгийн магистр (Ms.Econ) зэрэгтэй төгссөн, 2019 оноос БНХАУ-ын Эдийн Засаг, Бизнесийн Их Сургуульд Бизнесийн эдийн засгийн докторантаар (PhD candidate) суралцаж буй.

А.Батпүрэв нь Ашид Ассет Менежмент ҮЦК, Инфорум Консалтинг, ШИМТ Боловсрол компаниудын үүсгэн байгуулагч партнер, Монголын Хөрөнгийн Бирж ХК-ын Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн, Санхүүгийн Хүртээмж-Хөгжил Санаачилга ТББ-ын үүсгэн байгуулагч гишүүн.

Хөрөнгө оруулалт хариуцсан захирал Б. Цэлмэг

Банк, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр JPMorgan, SMBC aviation capital, Хас банк зэрэг олон улсын томоохон компаниудад 10 гаруй жил ажилласан туршлагатай. 2008 онд Irish American University-г Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгсөж 2016 онд АССА буюу Олон улсын нягтлан бодогч цолыг авсан. Тэрбээр Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны үнэмлэх, мөн Ирландын Банкарүүдын холбоо,

Хуульч нарын холбооны тус тус мэргэжлийн үнэмлэхтэй.

Хөрөнгө оруулалтын зөвлөх Б. Батгариг

Эдийн засагч, Санхүүч мэргэжилтэй, ОУ-ын Санхүүчдийн CFA нийгэмлэгийн CFA level II candidate. "Ашид Ассет Менежмент ҮЦК" ХХК-ийн Сангийн менежер, санхүүгийн шинжээч бөгөөд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Бизнесийн байгууллагуудад болон Европын сэргээн босголт, хөгжлийн банкны/ЕСБХБ/төсөлдээр санхүүгийн менежерээр ажиллаж байсан туршлагатай. Санхүүгийн шинжээчийн хувьд хөрөнгө оруулалтын багцын удирдлага, эрсдэлийн менежмент болон компанийн үнэлгээний чиглэлээр мэргэшсэн. МҮЦАЭХ-ноос олгодог хөрөнгө зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхтэй, Санхүүгийн Зохицуулах Хорооны "зохистой этгээд"-ийн шаардлагыг бүрэн хангасан.

Хөрөнгө оруулалтын зөвлөх Р.Сүвдгэрэл

Санхүүч, Монголын мэргэшсэн нягтлан бодогч, Татварын мэргэшсэн зөвлөх, бизнесийн зөвлөх. Эрнст Энд Яг Монголиа олон улсын аудитын фирм, Траст трейд ХХК-д ажиллаж үйлдвэрлэл, худалдааны олон байгууллагуудад санхүүгийн аудит, процессийн шинжилгээ хийн, төслийн удирдлага, хөрөнгө оруулалт зээлийн томоохон төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай. Үйлдвэрийн байгууллагуудийн санхүүгийн зөвлөх үйлчилгээний Дэвжих Партнерс ХХК-н үүсгэн байгуулагч, санхүүгийн зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай. БНХАУ-н Ардын их сургууль Олон улсын худалдаа эдийн засагч мэргэжлээр Бакалавр, БНХАУ-н Ардын их

сургууль Банк Санхүүч мэргэжлээр Магистр зэрэгтэй.

Зах зээлийн шинжээч Г. Ариунзаяа.

МУИС-ийн Бизнесийн сургуулийг санхүү менежмент мэргэжлээр төгссөн. "Монголын Үнэт Цаас Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ-өөс Монгол Улсын үнэт цаасны зах зээлд Хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллах эрхийн үнэмлэхтэй.

Дата аналит Ц. Булгансайхан

МУИС-ын Бизнесийн сургууль Санхүү менежмент, бакалавр зэрэгтэй. Ковидын үеийн чанаргүй зээлийн эдийн засагт үзүүлэх нөлөө болон нийгмийн халамжийн эдийн засагт үзүүлэх нөлөө зэрэг судалгааны ажил гүйцэтгэж байсан. АДРА олон улсын байгууллагат нягтлан бодогчоор ажиллаж байсан, залуу боловсон хүчин.

Санхүүгийн шинжээч Э. Мөнхболд

МУИС-ын Бизнесийн сургууль Санхүү менежмент мэргэжлээр төгссөн. Компанийн санхүүгийн шинжилгээ, төлөвлөлт, үнэлгээний чиглэлээр мэргэшиж буй залуу боловсон хүчин.

Дотоод хяналтын мэргэжилтэн Б. Бадамсүрэн
 Санхүү Эдийн Засгийн Их сургуулийг 2021 онд санхүү менежментийн мэргэжлээр төгссөн. 2021 онд "Монголын Үнэт Цаас Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ-өөс Монгол Улсын үнэт цаасны зах зээлд Хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх авсан болно. Мөн тус онд Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Даатгалын Зуучлагчдын Холбооноос хамтран зохион байгуулсан "Даатгалын зуучлагчийн эрх олгох сургалт"-ын гэрчилгээ авсан болно. 2021 оноос "Нэйшнл Иншуранс Брокерэйж Сервисэс" ХХК-ийн даатгалын мэргэжилтнээр ажиллаж байгаад өнөөдрийн байдлаар "Ашид Ассет Менежмент ҮЦК" ХХК-д дотоод ажилтнаар ажиллаж байна.

Борлуулалт, харилцагчийн үйлчилгээний мэргэжилтэн О. Урангоо

Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг 2021 онд санхүүгийн менежмент мэргэжлээр төгссөн ба 8-р сараас хойш "Нэйшнл Иншуранс

Брокерэйж Сервисэс" ХХК-д даатгалын мэргэжилтнээр ажиллаж байна. 2021 онд Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Даатгалын Зуучлагчдын холбооны хамтран зохион байгуулсан "Даатгалын зуучлагчийн эрх олгох сургалт"-нд хамрагдаж гэрчилгээ авсан ба мөн тус оны 11 сард Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооноос Монгол Улсын үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх авсан.

6.6 БУСАД

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар хамтын хөрөнгө оруулалтын санг Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй Хөрөнгө оруулалтын менежментийн компани үүсгэн байгуулж, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд сангийн хөрөнгийг удирдаж, сангийн тухайлсан бүртгэлийг тусгай зөвшөөрөлтэй кастодиан үйлчилгээ үзүүлэгчээр эрхлэхээр хуульчлагдсан.

"Ашид Арвижих" хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй "Ашид ассет менежмент ҮЦК" ХХК үүсгэн байгуулж, хөрөнгийг удирдах бөгөөд кастодианы үйлчилгээг "Голомт банк" ХХК-ийн Кастодианы хэлтэс үзүүлж, тухайлсан бүртгэлийг хөтлөхөөр холбогдох гэрээний төслийг хамтран боловсруулсан. Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулах баримт бичгийг хөрөнгө оруулалтын менежментийн компанийн гүйцэтгэх захирал, сангийн менежер хариуцан гүйцэтгэж, сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдээс хяналт тавин ажилласан болно.


"Ашид менежмент ҮЦК" ХХК нь "Ашид Арвижих" хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулахтай холбоотойгоор хуулийн үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу "Хэруга Партнэрс" хуулийн фирмээс сангийн дүрэм, журам боловсруулах, компанийн засаглалыг сайжруулах тал дээр хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ авч ажилласан.

"Гүүдсек ҮЦК"-ийн орон нутаг дахь салбаруудаар дамжуулан Хамтын хөрөнгө оруулалтын сан, Нээлттэй хөрөнгө оруулалтын сан, нэгж эрхийн танилцуулга

зэргийг хөрөнгө оруулагч нарт танилцуулах зөвлөгөө, үйлчилгээ авч ажиллаж байна.

“Мераки Коор” маркетингийн агентлагаас брэндинг, маркетингийн зөвлөгөө, үйлчилгээ авч байгаа бөгөөд туршлагатай IT багаас онлайн платформ хөгжүүлэлт хийлгэсэн бөгөөд энэхүү систем нь хөрөнгийн бирж, брокер, кастодиан банк зэрэг гуравдагч байгууллагуудтай API холболтоор шууд холбогдож, өгөгдлийг хугацааны алдагдалгүй дамжуулж ажиллах бөгөөд хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгө оруулалт хийсэн нэгж эрхийн үнэ цэнийг real time харж чадах давуу талтай. Системийг тестийн орчинд туршилтууд амжилттай хийгдэж дууссан.

Мөн МУИС-ийн эдийн засгийн сургуулийн судлаачдын багаас “Хөрөнгө оруулагчдын чадамжийг тодорхойлох аргачлал боловсруулах” үйлчилгээг авсан бөгөөд энэхүү судалгааны үр дүнгээр бий болсон аргачлалаар хөрөнгө оруулагчийн чадамжийг үнэлж, түүнд тохирсон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах боломжтой болох юм.





ashid

Asset Management

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 8-р хороо, Энхтайваны өргөн чөлөө,
Сити тауэр, 1001 тоот

Утас: +976 7766 1112

И-мэйл: contact@ashidasset.mn

web: ashidasset.mn